



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (439)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг шүүгчийн албан тушаалд томилох тухай*
- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *"Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр" батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны гуравдугаар сарын 14

№10 (439)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

140.	Зарим хүнийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 30	250
141.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 31	250
142.	Базарын Цэдэн-Ишид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай	Дугаар 40	250
143.	Очирын Шагдаржавт Монгол Улсын гавъяат уурхайчин цол хүртээх тухай	Дугаар 41	250
144.	Дахын Готовт Монгол Улсын гавъяат холбоочин цол хүртээх тухай	Дугаар 42	251
145.	Будын Намсрайд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай	Дугаар 43	251
146.	Галсангийн Тогтоход Монгол Улсын хүний гавъяат эмч цол хүртээх тухай	Дугаар 44	251
147.	Дашдоржийн Цэрэндаваад Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 45	251
148.	Аюурзанын Цанжидад Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай	Дугаар 46	252
149.	Шатарын Тогоод Монгол Улсын гавъяат эдийн засагч цол хүртээх тухай	Дугаар 47	252
150.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 48	252
151.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 54	256
152.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 55	256
153.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 56	256

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

154.	"Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр" батлах тухай	Дугаар 246	257
155.	Үнэлгээ, хураамжийн хувь хэмжээ батлах тухай	Дугаар 248	277
156.	Хөтөлбөрийг үргэлжлүүлэх тухай	Дугаар 249	281
157.	Жагсаалтад нэмэлт оруулах тухай	Дугаар 252	281
158.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 254	281
159.	Эрүүл мэндийн даатгалын 2006 оны шимтгэлийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 260	282
160.	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 264	282
161.	Журам батлах тухай	Дугаар 265	283

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 03—ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4, 58 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон Чойнорын Алтанцэцэгийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Цээлийн Амаржаргалыг Ховд аймаг дахь

сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь дууссан Гунаагийн Сүрэнг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 03—ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Сайнцагтын Жаргалыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Нарантуяагийн Сарангүнг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Чойнорын

Алтанцэцэгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Цээлийн Амаржаргалыг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27—ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Базарын Цэдэн-Ишид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Хилийн цэрэг, дипломат албанд он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа болсон улсын хилийг тогтоох, түүнийг гэрээ хэлэлцээр байгуулж баталгаажуулах, хилийн түүхийг судлах, улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэх үйлст оруулсан гарамгай хувь нэмрийг нь

үнэлж Базарын Цэдэн-Ишид Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27—ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Очирын Шагдаржавт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай

Нүүрсний аж үйлдвэрийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн хамт олныг чадамгай удирдан зохион байгуулан, нүүрс олборлолт, борлуулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн үзүүлэлтүүдийг дээшлүүлэн төвийн эрчим хүчний системийг нүүрсээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг

нь үнэлж Говьсүмбэр аймаг дахь "Шивээ-Овоо" ХК-ийн гүйцэтгэх захирал Очирын Шагдаржавт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээсүгэй.

 МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27–ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар хот

Дахын Готовт Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээх тухай

Төрийн болон төрийн бус байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж манай улсын харилцаа холбооны салбарыг материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэн хөгжүүлэх, далайн хөгжилтэй орнуудаас үзүүлж байгаа тусламжийн үр өгөөжийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж Далайн орнуудтай хамтран ажиллах Монголын нийгэмлэгийн тэргүүн Дахын Готовт Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27–ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Будын Намсрайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Их, дээд сургуульд багш, тэнхмийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтнаар олон жил үр бүтээлтэй ажиллаж мэргэжлийн боловсон хүчин, удирдах ажилтан бэлтгэх, эдийн засгийн шинэ сэтгэлгээг төлөвшүүлэн, залуу үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж

Удирдлагын академийн Эдийн засгийн тэнхмийн багш Будын Намсрайд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27–ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Галсангийн Тогтоход Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээ үйлчилгээний чанарын түвшинг сайжруулан, тойргийн сумдын хэмжээнд эх, нялхсын эндэгдлийг тууштай бууруулж, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн

Төгрөг сум дахь Сум дундын нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч Галсангийн Тогтоход Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27–ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Дашдоржийн Цэрэндаваад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Авьяас билгээ хөгжүүлэн монгол ардын урт, богинын болон зохиолын олон арван дуу, тууль, маггаалыг чадварлаг хөөмийлж, хөдөлмөрчдөд урлаг, соёлоор үйлчлэх, ардын язгуур урлагийг хойч үедээ сургаж өвлүүлэх, хөөмийн урлагыг гадаад, дотоодод сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Ховд аймгийн

Чандмань сумын иргэн, хөөмийч Дашдоржийн Цэрэндаваад Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Аюурзанын Цанжидад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Төрийн болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж улс төрийн шинжлэх ухаан, соёл судлалын бүтээлүүд туурвиж, төрийн бодлого боловсруулалцах, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь

үнэлж УИХ-ын гишүүн Аюурзанын Цанжидад Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Шатарын Тогоод Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж худалдаа, үйлчилгээний менежментийг сайжруулж, хөдөөгийн хөдөлмөрчдийг өргөн хэрэглээний бараагаар хангах, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нь борлуулахад шуурхай үйлчлэн, амьдрал ахуйг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж Өвөрхангай аймгийн Сант сумын "Сантмандах" хоршооны дарга Шатарын Тогоод Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 2 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Монголын Эх орончдын өдрийг тохиолдуулан үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, тээвэр, цаг уур, уул уурхай, холбоо, хэвлэл мэдээлэл, төр

захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Норовын Алтанхуяг - Сангийн сайд асан, Ардчилсан намын гүйцэтгэх зөвлөлийн гишүүн
2. Чойжавын Баатар - Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх
3. Нямжавын Батбаяр - Монгол Улсын Их Хурлын гишүүн
4. Төгсжаргалын Ганди - Монгол Улсын Их Хурлын гишүүн
5. Долоонжингийн Идэвхтэн - Монгол Улсын Их Хурлын гишүүн
6. Даваасүрэнгийн Нарандэлгэр - Удирдлагын академийн Удирдлагын

систем, мэдээлэл технологийн тэнхмийн эрхлэгч

7. Сансрайн Пүрэвсүрэн - Төв аймгийн МАХН-ын хорооны дэргэдэх Ахмадын холбооны дарга

8. Дорлигжавын Уртнасан - Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга

9. Пунцагийн Цагаан - Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд асан, Ардчилсан намын гүйцэтгэх зөвлөлийн гишүүн

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Цэвэгсүрэнгийн Аавынхүү - Сүхбаатар аймгийн Асгат сумын Дөхөм багийн малчин
2. Сүвөйдилийн Азай - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн бага ангийн сургалтын технологич

3. Цэндийн Алтангэрэл - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны өндөр настан ахмад дайчин

4. Дарамрагчаагийн Амар - ЭМЯ-ны санхүү, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

5. Лхамын Аюуш - МАХН-ын Төв архивын эрхлэгч
6. Далхаагийн Баадай - Нийслэл дэх ашигт малтмал, геологи хайгуулын "Монгол газар" ХХК-ийн зөвлөх геологич
7. Намжилсүрэнгийн Бадраа - УБТЗ-ын эрчим хүч, ус хангамжийн 2 дугаар ангийн дарга
8. Рэгээдмаагийн Бадралмаа - Удирдлагын академийн сургалтын албаны дарга
9. Тогооборын Базардар - Дундговь аймгийн Сайнцагаан сум дахь "Дундговь Ус" ХХК-ийн ерөнхий менежер
10. Пагамын Базаррагчаа - Говьсүмбэр аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга, МАХН-ын Бага хурлын гишүүн
11. Сангийн Баянжаргал - Өвөрхангай аймгийн Уянга сумын 8 жилийн сургуулийн математикийн багш
12. Намжилын Баяр - Нийслэлийн Баянгол дүүрэг дэх "Мечта" хувийн дунд сургуулийн захирал
13. Цогбадрахын Баяраа - МАХН-ын Хэлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга
14. Гочоогийн Баярсайхан - Завхан аймгийн Баянхайрхан сумын Засаг даргын орлогч бөгөөд Төрийн сангийн төлөөлөгч
15. Гомбын Баясгалан - Нийслэл дэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Золхайрхан" ХХК-ийн ерөнхий захирал
16. Батаагийн Биньээ - ХХААЯ-ны Стратегийн бодлогын хэлтсийн дарга
17. Мэндээхүүгийн Бямбаа - Баянхонгор аймгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний "Би-Энхтөгөлдөр" ХХК-ийн ерөнхий захирал
18. Буриадын Галбадрах - Хөвсгөл аймаг дахь Хөдөөгийн ядуурлыг бууруулах төслийн захирал
19. Шагдарын Ганбат - Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчны албаны дарга
20. Дэчинсүрэнгийн Гансүх - Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн түшмэл
21. Чимэдцэрэнгийн Гантөмөр - Дорнод аймгийн "Дорнод нийтийн аж ахуй" ХХК-ийн захирал
22. Цэрэндоржийн Ганхуяг - Иргэний Зориг-Бүгд Найрамдах Намын дэд дарга
23. Түгжваандангийн Гончигдорж - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд Арвайхээр хотын захиралч
24. Найдангийн Гомбосүрэн - МУИС-ийн Биологийн факультетийн Ой судлалын тэнхимийн багш
25. Бат-Очирын Гунгаа - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 11 жилийн 1 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
26. Лувсандоржийн Гүнчин - Дархан-Уул аймгийн ИТХТ-ийн дарга, аймгийн МАХН-ын хорооны дарга
27. Гүнсэндэшийн Дорждагва - Эрүүл мэндийн яамны алсын дуудлагын жолооч
28. Дамбын Дүгэр - Өмнөговь аймгийн Булган сумын хүн эмнэлгийн сувилагч
29. Цагаачийн Жавзан - Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын дунд сургуулийн сургалтын менежер
30. Чойжилжавын Жавзан - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 жилийн 44 дүгээр сургуулийн математикийн багш
31. Бүргэджанцангийн Жаргалсайхан - Дархан-Уул аймгийн "Дархан Дулааны шугам сүлжээ" ХК-ийн санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
32. Цогийн Жүгдэр - Говь-Алтай аймгийн Дарив сумын холбооны салбарын эрхлэгч
33. Ядамцоогийн Жүгдэр - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын эрчим хүчний "Ундрам-Оюу" ХХК-ийн захирал
34. Аюушийн Зундуй - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн МАХН-ын хорооны дэд дарга
35. Лхагвадашийн Ичинхорлоо - Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн технологийн багш
36. Борхондойн Индра - Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн "Монгол мессенжер" сонин эрхлэгч
37. Тердикбайн Күшай - Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
38. Буянтогтохын Лонжоо - Баян-Өлгий аймгийн Цагааннуур тосгоны 8 жилийн дунд сургуулийн захирал, аймгийн МАХН-ын хорооны гишүүн
39. Бадарчийн Лосол - МАХН-ын Сан хөрөнгийн хэлтсийн дарга
40. Бурмаагийн Маамуу - Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч
41. Ендонгийн Найгал - Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь "Эрдэнэ-Зуу" музейн захирал
42. Ядамын Насандэлгэр - Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч
43. Цэгмидийн Нямдорж - Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум дахь "Түмэнцогт" ОНӨҮГ-ын захирал
44. Чойжилын Очирбат - ХХААЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн
45. Алтангэрэлийн Оюун - С.Зоригийн нэрэмжит "Санко" менежментийн коллежийн захирал
46. Даваадоржийн Оюунбат - Орхон аймгийн ИТХТ-ийн дарга, аймгийн МАХН-ын хорооны дарга
47. Балгаагийн Өлзийдаш - Ховд аймгийн Жаргалант сумын 11 жилийн 2 дугаар сургуулийн хөдөлмөрийн багш
48. Бүдээгийн Пүрэвжав - Өмнөговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмгэг судлаач-шүүх эмнэлгийн их эмч
49. Доржпүрэвийн Рэнцэндорж - Төв аймгийн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газрын дарга

50. Чимэдийн Сайханбилэг - Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга

51. Пүрэвжалын Саманд - Завхан аймгийн Тээвэр зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн

52. Доржийн Сумъяа - Архангай аймгийн Өндөр-Улаан сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч

53. Цэрэнсономын Сүхбаатар - МАХН-ын Хяналтын ерөнхий хорооны дарга

54. Дамдінсүрэнгийн Сэрээтэр - МОНЦАМЭ агентлагийн Говь-Алтай аймаг дахь сурвалжлагч

55. Чулууны Таяа - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Континентал" ХХК-ийн "Континентал" зочид буудлын ерөнхий захирал

56. Чойнорын Түдэндорж - Хөвсгөл аймгийн барилга, зам гүүр, барилгын материалын үйлдвэрлэлийн "Олонгол трейд" ХХК-ийн зөвлөх инженер

57. Тайфын Хангай - Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 4 дүгээр багийн Засаг дарга, МАХН-ын үүрийн дарга

58. Ядамын Хандаа - Архангай аймгийн Өгийнуур сумын Дойт багийн өндөр настан, ахмад саальчин

59. Нямаагийн Хишигжаргал - Дорнод аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн захирал

60. Санжхүүгийн Хорлоо - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн

61. Пүрэвдоржийн Цогтбаатар - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг дарга

62. Рагчаагийн Цэрэн - Хэнтий аймгийн Баянхутаг сумын малчин

63. Сандагийн Цэрэнням - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл эрхэлсэн "М-Си-Эс интернэйшнл" ХХК-ийн цахилгааны хэлтсийн дарга

64. Бизъяагийн Цэцэгээ - Нийслэлийн "Намдол-Дэчилэн" хийдийн зоч лам

65. Гомбодоржийн Цэцэгдэр - ЭМЯ-ны Эрүүл мэндийн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн

66. Пунцагийн Чимид - "Газарчин" дээд сургуулийн Ашигт малтмалын тэнхмийн эрхлэгч

67. Раашийн Чимэд - Увс аймгийн Улаангом сумын Засаг даргын Тамгын газрын дарга

68. Чойжамцэн Чулуунбаатар - ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газрын ахлах мэргэжилтэн

69. Рэнцэнгийн Эрдэнэбаатар - Удирдлагын академийн Төрийн улирлалын тэнхмийн ахлах багш

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Момолын Төмөрбаатар - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх

Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Түвдэнгийн Алтанцэцэг - Удирдлагын академийн Социологи сэтгэл зүйн тэнхмийн багш

2. Ивановын Амартүвшин - Архангай аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол хөгжимчин

3. Моломын Анжил - Увс аймгийн Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч

4. Самдангийн Баасанбат - Архангай аймгийн "Кодак" гэрэл зургийн төвийн менежер

5. Жамбаагийн Балдан - Сүхбаатар аймгийн Асгат сумын Дөхөм багийн малчин

6. Цэгмидийн Батбаатар - Нийслэл дэх Монгол Японы хамтарсан "Хасэбэ интернэйшнл" ХХК-ийн ерөнхий захирал

7. Цэрэндоржийн Батдорж - ЭМЯ-ны аж ахуй, мөнгөний нярав

8. Пунцагийн Бат-Очир - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 жилийн 50 дугаар сургуулийн техник технологийн багш

9. Дэнзэнгийн Батсайхан - Өмнөговь аймгийн "Шивээ хурэн" боомтын дарга, Ардчилсан намын гишүүн

10. Мажисүрэнгийн Баттуяа - Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн тэрэх тасгийн нярайн их эмч

11. Тогтохын Баясгалан - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн математикийн багш

12. Цэрэндагвын Булган - Архангай аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол бүжигчин

13. Мантайн Борхүү - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

14. Эрдэнийн Ганболд - Улсын Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга, МоАХ-ны гишүүн

15. Дагвын Гантөгс - "Шри шри бясалгалын Монголын холбоо" ТББ-ын тэргүүн

16. Чойдонгийн Ганцэцэг - Нийслэл дэх хөнгөн үйлдвэрлэлийн "Ханбогд кашемир" ХХК-ийн захирал

17. Нямдалайн Гүнсмаа - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Засаг даргын Тамгын газрын хүн ам, нийгмийн хамгааллын ажилтан

18. Гомбын Даваадорж - Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

19. Намбарын Даваадорж - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны Засаг дарга, МАХН-ын үүрийн дарга

20. Цэрэнбадамын Дагва - Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн ерөнхий нягтлан бодогч, цагдаагийн дэд хурандаа

21. Дашцэрэнгийн Дарьсүрэн - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Хүмүүн" цогцолборын 3 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
22. Ендонгийн Довдонсүрэн - Архангай аймгийн Өлзийт сумын татварын улсын байцаагч
23. Цэрэнгийн Долгормаа - Дорнод аймгийн Баянцун сумын 11 жилийн сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
24. Дашийн Донров - Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байцаагч
25. Лувсандоржийн Доржсүрэн - Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын байр ашиглалтын албаны дарга, МоАХ-ны гишүүн
26. Дэмбэрэлийн Доржханд - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 11 жилийн 68 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
27. Доржийн Дуламсүрэн - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Хүмүүн" цогцолборын 3 дугаар сургуулийн сургалтын менежер
28. Лхангаагийн Жавзан - Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн үйлчлэгч
29. Доржсүрэнгийн Жавзмаа - Завхан аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн эрхлэгч, их эмч
30. Балдангийн Жавхлан - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын газар тариалангийн "Бага Хангай" ХХК-ийн захирал
31. Алтангэрэлийн Жаргалсайхан - Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөр эрүүл ахуйн хяналтын байцаагч
32. Гантөмөрийн Замбага - Завхан аймгийн Яруу сумын "Хэц-Улаан" багийн малчин
33. Дорждэрэмийн Мажисүрэн - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Тэмүүлэл" цогцолбор сургуулийн бага ангийн багш
34. Ганжидын Мандах - Гэмтэл, согог сэргээн засалтын клиникийн эмнэлгийн түлэнхийн тасгийн ахлах сувилагч
35. Жутмааны Манушка - Нийслэлийн Багахангай дүүргийн ус суваг ашиглалтын товчооны дарга
36. Пүрэвийн Мөнхбаяр - Нийслэлийн "Сант марал сан" ТББ-ын зохицуулагч, Ардчилсан намын гишүүн
37. Довдонгийн Мөнхжаргал - Төв аймгийн Эрдэнэ сумын нийгмийн даатгалын улсын байцаагч
38. Дэмбэрэлийн Наран - Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын хуулийн зөвлөх, МоАХ-ны гишүүн
39. Паламын Нарантуяа - "Монгол кино" нэгтгэлийн кино эвлүүлэгч
40. Содномын Нацагдорж - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны Засаг дарга, МАХН-ын үүрийн дарга
41. Пүрэвсүрэнгийн Нямгэрэл - "Газарчин" дээд сургуулийн тэнхмийн эрхлэгч
42. Сэндэнгийн Нямдорж - Нийслэлийн Налайх дүүрэг дэх "Налайхын дулааны станц" ХК-ийн тоног төхөөрөмжийн засварчин
43. Лувсандоржийн Отгондалай - Нийслэлийн "Монгол шуудан" ХХК-ийн шуудан хүргэгч
44. Оросоогийн Оюун - Нийслэлийн МАХН-ын хорооны Хяналтын хорооны дарга
45. Дашдэндэвийн Оюунчимэг - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын "Хүмүүн" цогцолборын 3 дугаар сургуулийн бага ангийн багш
46. Осоржамын Оюунчимэг - УБТЗ-ын Багахангай өртөөний техник мэдээлэгч
47. Сүхбаатарын Өлзийхутаг - Дорнод аймгийн Баян-Уул сумын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
48. Ендонгийн Пүрэвдулам - УИХ дахь МАХН-ын бүлгийн ажлын албаны зөвлөх
49. Очирхуягийн Содовжамц - Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга
50. Чоглойн Соль - Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
51. Манигайн Сугар - Нийслэл дэх "Эрчим хүчний барилга угсралтын трест" ХК-ийн инженер
52. Жамбаагийн Тамир - МАХН-ын Сан хөрөнгийн хэлтсийн санхүү, тайлан бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч
53. Моломын Толя - Орхон аймгийн МАХН-ын хорооны улс төрийн ахлах ажилтан
54. Ендонгийн Туул - Нийслэлийн Багануур дүүргийн ЛЭОС-ийн гүйцэтгэх захирал
55. Намдагийн Туул - "Сэрүүлэг" дээд сургуулийн сургалт эрхэлсэн захирал
56. Осорын Хүрэлбаатар - Дорнод аймгийн "Талын сувд" ХХК-ийн ерөнхий захирал
57. Аюураанын Хүрэлшайг - Улсын Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дэд дарга
58. Мангалын Цагаан - Нийслэл дэх ашигт малтмал, геолог хайгуулын "Монгол газар" ХХК-ийн Өмнөговь аймаг дахь Олон-Овоотын хүдэр баяжуулах үйлдвэрийн аж ахуйн дарга
59. Должингийн Цогбадрах - С.Зоригийн нэрэмжит "Санко" менежментийн коллежийн эрдмийн зөвлөлийн гишүүн, МоАХ-ны гишүүн
60. Лодойн Цэен - Нийслэлийн эмийн үйлдвэрлэлийн "Монос фарм" ХХК-ийн нярав
61. Дашнямын Цэрэнханд - Дорнод аймгийн Хэрлэн сумын төрөлжсөн сургалттай 12 дугаар сургуулийн сургалтын менежер
62. Дашравдангийн Цэцэгмаа - Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч
63. Рэнчингийн Чойжилсүрэн - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын хувийн мал эмнэлэг "ДЖМ" хоршооны малын их эмч
64. Сайрийсүрэнгийн Шагдартовуу - Удирдлагын академийн Нийгмийн удирдлагын тэнхмийн багш



65. Равдангийн Энхтуяа - Дорнод аймгийн Дашбалбар сумын 11 жилийн сургуулийн дотуур байрны тогоч

66. Төмөрбаатарын Энхтуяа - Барилга, хот байгуулалтын яамны "Гэр хорооллыг дэмжих" төслийн ажилтан, Ардчилсан намын гишүүн

67. Цэдэвсүрэнгийн Энхтуяа - Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга

68. Төмөрбаатарын Эрдэнэ - Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн ажлын албаны зөвлөх

69. Цэвээнжавын Эрдэнэцогт - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга

70. Занын Эрдэнэцэцэг - Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотор-мэдрэлийн тасгийн ахлах сувилагч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Австрали Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Лувсандагвын Амарсанааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Австрали Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Галсангийн Батсүхийг тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Лалын Бүгд Найрамдах Пакистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Лувсандагвын Амарсанааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Лалын Бүгд Найрамдах Пакистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Галсангийн Батсүхийг тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Лувсандагвын Амарсанааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Галсангийн Батсүхийг тохоон томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандиалагчдын зээл, тусламжийн тодорхой хэсгийг чиглүүлэх, дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Т.Ганди, Сангийн сайд Н.Алтанхуяг, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулж хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн П улиралд

"Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр" батлах тухай

Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Т.Гандид үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хүн амын эрүүл мэндийн боловсрол үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 5 дугаар тогтоол, "Хорт хавдартай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1997 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 80 дугаар тогтоол, "Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 139 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
ЦЭЛБЭГДОРЖ
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Т.ГАНДИ

Засгийн газрын 2005 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхий дахинд хүн амын өвчлөлийн байдал өөрчлөгдөж соёл иргэншил, амьдралын буруу хэв маяг буюу зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээтэй холбоотой халдварт бус өвчин (цаашид "ХБӨ" гэх) өөр өвчлөгсдийн тоо асар хурдацтай нэмэгдэж нийгэм, эдийн засгийн хөгжил болоод сая сая хүний амьдрал, эрүүл мэндэд давхар дарамт учруулж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (цаашид "ДЭМБ" гэх)-ын тооцолсноор 2005 онд 35 сая хүн буюу дэлхийн хэмжээний нийт нас баралтын 60 хувийг ХБӨ (зүрхний өвчин, тархины цус харвалт, хавдар, чихрийн шижин, амьсгалын замын архаг өвчин) эзлэж байгаа бөгөөд энэ нь халдварт өвчин (ДОХ, сүрьеэ, хумхаа зэрэг) жирэмслэлт, төрөлт болон хоол, тэжээлийн дутагдлын улмаас шалтгаалсан нас баралтаас 2 дахин их байна.

Дэлхийн хэмжээнд хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж байгаа зонхилох 10 эрсдэлт хүчин зүйлээс хамгийн түгээмэл, анхдагч эрсдэлт хүчин зүйл нь зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхины хэрэглээ бөгөөд эдгээр нь илүүдэл жин, цусны даралт ихсэлт, цусан дахь өөх тос, саахар (глюкоз)-ын хэмжээ нэмэгдэх зэрэг завсрын хүчин зүйл байдлаар илэрч улмаар

өвчлөл, нас баралтад хүргэж байгааг ДЭМБ тогтоогоод байна.

Эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талаар үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлсэн энгийн бөгөөд үр дүнтэй арга, хувь хүний анхаарал, хүчин чармайлт нь ХБӨ-ий улмаас тахир дутуу болох, нас барах явдлыг 50 хүртэл хувиар бууруулж чаддаг байна. Тухайлбал зан үйлийн буруу дадлаа өөрчлөх буюу хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгон зохистой хооллож, идэвхтэй хөдөлгөөнийг эрхэмлэн биеийн жингээ хэвийн хэмжээнд барьж, архи, тамхины хэрэглээг багасгавал зүрх судасны өвчнийг 80 хувь, чихрийн шижингийн 2 дугаар хэлбэрийг 90 хүртэл хувиар, хавдрын тохиолдлыг 1/3-ээр багасгаж болно гэж ДЭМБ үзэж байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр 1990 онд манай хүн амын нас баралтын шалтгааны дотор зүрх судасны өвчин, хавдар нь 2 ба 3 дугаарт ордог байсан бол 1993 оноос эхлэн нас баралтын шалтгааны дотор зүрх судасны өвчин эрс нэмэгдэн тэргүүлж, хавдар, осол гэмтэл удаах байрыг эзлэх болсны дээр сүүлийн жилүүдэд чихрийн шижин өвчний тархалт хурдацтай нэмэгдэх хандлагатай байгааг манай судлаачид тогтоогоод байна.

Хүн амын нас баралтын шалтгааны дотор халдварт бус өвчин давамгайлж байгаагаараа монгол хүний дундаж наслалтад ч нөлөөлж байна. Тухайлбал 1990 онд монгол хүний дундаж наслалт 63.7 байснаа 1992 онд 62.8 болж буурал 2003 онд

63.6, 2004 онд 64.5 болж нэмэгдсэн хэдий ч 1990 онтой харьцуулахад дундаж наслалтад тодорхой өөрчлөлт гараагүй байна.

ХБӨ манай оронд жил тутам нэмэгдэж байгааг харгалзан хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлсэн хэдий ч үйл ажиллагаа нь уялдаа холбоо муутай, нөөц, чадавхи хангалтгүй зэрэг сөрөг тал ажиглагдаж байна.

Ганц нэг эрсдэлт хүчин зүйлд чиглэсэн салангйд олон судалгаа хийдэг боловч эрсдэлт хүчин зүйлийг байнга хянаж, шаардлагатай арга хэмжээ авч байхад чиглэгдсэн ХБӨ-ий хяналт, тандалтын тогтолцоо бүрдээгүй байна.

Иймээс ДЭМБ-ын зөвлөмж, дэлхий нийтийн жишгээр нэг өвчин, нэг эрсдэлт хүчин зүйлд илүүтэй анхаарч байсан хуучин арга, хандлагыг өөрчлөн нийтлэг хэд хэдэн эрсдэлт хүчин зүйлд иж бүрэн хандаж тэдгээрийг бууруулснаар хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа хэд хэдэн өвчнийг нэгэн зэрэг бууруулах өртөг зардал багатай, үр ашиг сайтай шинэ хандлага, үйл ажиллагаанд шилжих явдал чухал байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хугацаа, зарчим, санхүүжилт

2.1. Халдварт бус өвчин тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн хяналт, тандалтыг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих замаар хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс шалтгаалсан нас баралтыг бууруулахад энэхүү хөдөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийг 2013 он хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 1 дүгээр үе шат 2006-2009 он, 2 дугаар үе шат 2010-2013 он байна.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

а/иргэд, хамт олны дунд эрүүл аж төрөх зан үйл төлөвшихөд дэмжлэг үзүүлэхүйц "эрүүл мэндийг дэмжигч" орчин бүрдүүлэх, ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлана; б/зонхилон тохиолдох ХБӨ-д нөлөөлөгч нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах талаар бодлого боловсруулж чадавхи бүрдүүлэх, түншлэх, мэдээллээр хангах болон хэрэгжүүлэх бүх түвшинд иж бүрнээр хандана;

в/иргэд, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн оролцоог хангана;

г/нийт хүн ам, өвчлөх эрсдэлтэй бүлэг болон өвчилсөн хувь хүн аль алинд нь чиглэсэн иж бүрэн хандлага, баримт нотолгоонд түшиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

д/одоогийн байгаа дэд бүтэц болон нөөцөд тулгуурлан эрүүл мэндийг дэмжих, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, анхдагч шатлалын болон эмнэл зүйн тусламжийн тасралтгүй байдлыг хангана;

е/нийгмийн эрүүл мэндийн бусад хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулан үр ашгийг дээшлүүлнэ.

2.4. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

б/Шинжлэх ухаан, технологийн, Архидан согтуурахтай тэмцэх, Эрүүл мэндийг дэмжих зэрэг Засгийн газрын тусгай зориулалтын сангаас олгох хөрөнгө;

в/гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

г/олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хандив;

д/бусад эх үүсвэр.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.1. Зорилт. 1. Зүрх судас, хавдар, чихрийн шижин зэрэг зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааг удирдан зохицуулах тогтвортой механизмыг бүрдүүлнэ.

3.1.1. ХБӨ-нөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийг мэргэжил, арга зүйн хувьд удирдан зохицуулах тогтвортой механизмыг бий болгох;

3.1.2. зонхилон тохиолдох ХБӨ-ий өвчлөл, нас баралт, тэдгээрийн өртөг зардлыг хянах, мэдээлэх ажлыг тогтмол явуулах чиглэлээр эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох;

3.1.3. ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын байдлыг тогтмол судлан тандах тогтолцоо бүрдүүлэх.

Хүрэх үр дүн: Зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааг удирдан зохицуулах механизмтай болж өвчлөл, нас баралт, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийг хянан тандах тогтолцоо бүрдэнэ.

3.2. Зорилт 2. Эрүүл амьдралын хэв маяг, эзлэлт орчныг дэмжсэнээр зонхилон тохиолдох ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийн түвшинг бууруулна.

3.2.1. хүн амын дунд малын гаралтай өөх, тос болон давс, саахарын хэрэглээг багасгах, жимс, ногооны хэрэглээг нэмэгдүүлэх замаар зохистой хооллолтыг төлөвшүүлэх чиглэлээр олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааг идэвхжүүлэх;

3.2.2. хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор зориулалтын зам, талбай, тоног төхөөрөмж, хэрэгслийн хүртээмж, чанар, гудамж талбайн гэрэлтүүлэг, аюулгүй байдлыг сайжруулах замаар хүн амын хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.3. тамхины хэрэглээг бууруулах зорилгоор татварыг тасралтгүй нэмэгдүүлэх, бүх

төрийн зар сурталчилгаа болон урлаг, нийтийн биеийн тамир, спорт зэрэг олон нийтийг хамарсан уралдаан, тэмцээн, арга хэмжээг тамхи үйлдвэрлэгчийн зүгээс ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа болон тамхины худалдаанд тавих хяналтыг сайжруулан тамхигүй орчин бүрдүүлэх;

3.2.4. согтууруулах ундааны хатуулаг, чанарыг нь харгалзан татварыг ялгавартай, дэс дараатай нэмэгдүүлэх, архи тамхины бүх төрлийн зар сурталчилгаа болон урлаг, нийтийн биеийн тамир, спорт зэрэг олон нийтийг хамарсан уралдаан, тэмцээн, арга хэмжээг согтууруулах ундаа үйлдвэрлэгчийн зүгээс ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа болон согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд тавих хяналтыг сайжруулан архигүй орчин бүрдүүлэх замаар зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

3.2.5. эрүүл мэндийг дэмжих талаар байгууллага, хамт олны чадавхийг дээшлүүлэн "Эрүүл мэндийг дэмжигч" хот, хороо, сум, баг, сургууль, ажлын байр, эмнэлэг, хамт олон, гэр бүлийн тоог нэмэгдүүлэх замаар иргэдэд эрүүл зан үйл төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх;

3.2.6. иргэдэд эрүүл аж төрөх, хүнсний бүтээгдэхүүнийг зохистой хэрэглэх дадал эзэмшүүлэх талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/хоол, хүнсний зүйлийн илчлэгийг хянан нас, ажлын онцлогт тохируулан хэрэглэж занших.

2/дараахь хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг багасгах:

а/малын өөх-тос;

б/давс;

в/элсэн чихэр, чихэр.

3/дараахь хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх:

а/жимс, ногоо;

б/ширхэглэг, үр тарианы хүнсний

бүтээгдэхүүн.

4/нэг удаагийн хэрэглээний хэмжээг тохируулах:

а/хэт их идэхгүй байх;

б/илчлэг ихтэй/өөх тос, чихэр ихтэй/

хоол, хүнсний бүтээгдэхүүн байнга хэрэглэхээс зайлсхийх.

5/зөв технологиор бэлтгэх, хэрэглэх:

а/хуурсан, шарсан, нөөшилсөн хоол,

хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг багасгах;

б/хоол, цайг хэт халуун хэрэглэхгүй

байх.

3.2.7. Хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/хүн бүр өдөр тутам наад зах нь 30 минут шаламгай алхах, дугуйгаар явах зэргээр идэвхтэй хөдөлгөөн хийх;

2/хүүхэд, залуучууд нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэх дасгалыг долоо хоногт 3 удаа 20 минутаас доошгүй хугацаагаар хийх;

3/биеийн жингээ тогтмол хэмжээнд барихын тулд өдөрт наад зах нь 1 цаг хүч тэнхээ шаардсан биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр хичээллэх;

4/цэцэрлэг, сургууль, хамт олны дунд өдрийн завсарлагаар идэвхитэй хөдөлгөөн, дасгал хийж хэвшүүлэх.

3.2.8. Тамхины хэрэглээг бууруулах талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/эрүүл мэндэд хор хөнөөлтэй тул тамхин бүтээгдэхүүний аливаа хэлбэрийг хэрэглэхийг цээрлэх;

2/тамхинд донтуулах үйлчилгээтэй никотин агуулагддаг тул сонирхож үзэхгүй байх;

3/дам тамхидалтаас сэргийлэх;

4/бусдын дэргэд тамхи татахгүй байх;

5/эрүүл мэндээ сайжруулахын тулд тамхинаас гарах.

3.2.9. Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1/хүүхэд, залуучууд архи уухгүй байх;

2/насанд хүрэгсдэд зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

3/эрүүл мэндээ сайжруулахын тулд

архинаас гарах.

Хүрэх үр дүн: Эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэх талаар чадавхи дээшлэн "эрүүл мэндийг дэмжигч" байгууллага, хамт олон, үйлдвэрлэл, үйлчилгээний тоо нэмэгдэж хүн амын дунд эрүүл зан үйл төлөвшин эрсдэлт хүчин зүйлийн тархалтын түвшин буурна.

Зорилт 3. Зонхилон тохиолдох ХБӨ-ий үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй (олон нийтийн оролцоог хангасан, тохиромжтой, хүртээмжтэй, үр дүнтэй) болгоно.

3.3.1. зонхилон тохиолдох ХБӨ-ийг эрт илрүүлэх скрининг, хянах үр дүн сайтай аргыг нэвтрүүлэх, үнэлгээ хийх;

3.3.2. эрүүл мэндийн анхдагч шатлалын тусламж (ЭМАШТ)-д суурилсан, зүрх судасны өвчин, чихрийн шижин, хавдрын нотолгоонд тулгуурласан эмнэл зүйн удирдамж, стандартыг боловсруулж хэрэгжүүлэх, энэ чиглэлээр эрүүл мэндийн хоёрдогч болон гуравдагч шатлалын түвшинд үндэсний чадамж бүрдүүлэх;

3.3.3. зонхилон тохиолдох ХБӨ-ийг бүртгэх, хянах, эмнэл зүйн үйлчилгээнд аудит хийх тогтолцоог өргөжүүлэх;

3.3.4. тамхинаас гаргах, цусны даралт, илүүдэл жинг бууруулах, таргалалтын хам шалтгааныг тодорхойлон эмчлэх зэрэг эрсдэлтэй бүлгийн хүн амд зориулсан эмчилгээ-сургалтын хөтөлбөр, удирдамж боловсруулан хэрэгжүүлэх;

3.3.5. ХБӨ-ий төгсгөлийн шатанд өвдөлт, бусад шинж тэмдгийг хөнгөвчлөн зовиур

шаналгаагүй байлгахад чиглэсэн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх.

Хүрэх үр дүн: Зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах нийгэм, хамт олонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бий болж тасралтгүй байдал, чанар, хүртээмж нь дээшилнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаанд бусад салбарын оролцоог идэвхжүүлэх, байгууллага, аж ахуйн нэгж болон олон улсын байгууллагын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл хариуцна.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангах, хяналт тавих ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн бусад байгууллага /Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв, Биеийн тамир, спортын улсын хороо, Хавдар судлалын төв зэрэг/-тай хамтран гүйцэтгэнэ. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүрэг бүхий салбар дундын ажлын бүлэг, түүний өдөр тутмын ажлыг гүйцэтгэх нэгж ажиллана.

4.3. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг даргаар ахлуулсан Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулж ажиллуулна. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл нь орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн I улиралд багтаан тайлагнана.

4.4. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг нэгтгэн дүнжж Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл, Засгийн газарт жил бүрийн II улиралд тайлагнаж байна.

4.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хүлээх үүрэг:

4.5.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/зонхилон тохиолдох ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг судлан байнгын хяналт, тандалт хийж бодлого, стратегид шаардлагатай өөрчлөлт хийж байх, энэ чиглэлээр чадавхи бүрдүүлэх;

2/ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх;

3/зонхилон тохиолдох ХБӨ, нас баралт болон эрсдэлт хүчин зүйлийн мэдээллийн сан байгуулах, мэдээллийн үзүүлэлтийг хянан боловсронгуй болгох;

4/ХБӨ-өөс урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагаанд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нөөцийг дайчлах;

5/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжин удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

6/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг бусад хөтөлбөр, төсөлтий уялдуулан хамтран ажиллах замаар хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх;

7/хүн амд зохистой хооллолт, хөдөлгөөний идэвх, архи, тамхигүй аж төрөхийн ач холбогдлын талаар мэдлэг, дадал төлөвшүүлэхэд чиглэгдсэн албан бус болон зайны сургалтын хөтөлбөр, гарын авлага, аргачлал, зөвлөмжийг холбогдох яам, газартай хамтран боловсруулж хэрэгжүүлэх.

8/зонхилон тохиолдох ХБӨ-ий үед үзүүлж байгаа эмнэл зүйн тусламж, үйлчилгээний дотор урьдчилан сэргийлэх арга хэмжээний эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд санхүүгийн болон бусад урамшуулал олгох эрх зүйн орчныг бий болгох;

9/ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, оношилгоо, эмчилгээний арга зүйн чиглэлээр ажиллах боловсон хүчнийг гадаад, дотоодод сургах, мэргэжлийг дээшлүүлэх;

10/зонхилон тохиолдох ХБӨ-ий оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг хянан шатлал бүрээр боловсруулж мөрдүүлэх;

11/зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах нэгдсэн үйл ажиллагааг сум, өрхийн эмнэлгээр үзүүлэх анхдагч шатлалын тусламж, үйлчилгээтэй уялдуулах, үр дүнг тооцох механизмыг боловсруулж мөрдүүлэх;

12/цусны даралт, цусан дахь холестерол, глюкозын хэмжээ, биеийн жин зэрэг үзүүлэлтийг өөрсдөө хянах дадал хэвшилд иргэдийг сургах, иргэд өөрсдөө хянах боломжтой, баталгаатай багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, эрсдэл бүхий хүмүүсийн зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрт гэр бүлийнх нь гишүүдийг оролцуулах зэргээр ХБӨ-ий хүндрэлээс сэргийлэх арга хэмжээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;



13/зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах талаар баримталж байгаа бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүн амын зан үйл, орчны өөрчлөлтийн байдалд судалгаа, үнэлгээ хийх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;

14/эрсдэлт хүчин зүйлийг бууруулахын ач холбогдлын талаар баримт нотолгоонд тулгуурласан ухуулга сурталчилгаа явуулах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах;

15/ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн дэд хөтөлбөр боловсруулж эрсдэлтэй бүлгийн хүн амын дунд сургалт явуулах;

16/хүн амын нас, ажил мэргэжлийн онцлогт тохирсон идэвхтэй хөдөлгөөний удирдамж, стандарт гарган нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангаж ажиллах;

17/эмчилгээний тураах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, төвүүдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг судлах.

4.5.2. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/хөтөлбөр хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, хандивлагчидтай идэвхтэй хамтран ажиллах;

2/зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах чиглэлээр үндэсний хэмжээнд баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрт тусгаж хэрэгжилтэд хяналт тавих.

4.5.3. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх;

2/архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх.

4.5.4. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/зохистой, эрүүл хооллолт, идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих, архи, тамхины хэрэглээ бууруулахад чиглэсэн татварын бодлого, зах зээлийн урамшууллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн төрийн захиргааны төв байгууллагын захиалга, тооцоог үндэслэн хянан шийдвэрлэж жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган санхүүжүүлж байх;

3/ХБӨ-өөс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

4/гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хөтөлбөрийн тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

4.5.5. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/эрүүл, зохистой хооллолт, идэвхитэй хөдөлгөөний ач холбогдол, архи, тамхины хор хөнөөлийн талаар суурь мэдлэг олгох чиглэлээр ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт нэмэлт оруулах;

2/бүх шатны боловсролын байгууллагад суралцагсдыг "эрүүл", халуун хоолоор үйлчлэх, буцалсан цэвэр ус уух боломжийг бүрдүүлэх, энэ чиглэлээр нийтийн хоолны газар, хүнсний үйлдвэртэй гэрээ байгуулж ажиллах;

3/ерөнхий боловсролын сургуулийн өдрийн хоол хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэх;

4/ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх, хүүхдийн хоолны хоногийн хэрэгцээ, илчлэгийн талаархи тогооч нарын мэдлэг, үр чадварыг сайжруулах;

5/суралцагсдыг хөдөлгөөний хөмсдолоос сэргийлэх, идэвхитэй хөдөлгөөн хийх, биеэ чийрэгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх;

6/сургуулийг архи, тамхигүй орчин болгох талаар арга хэмжээ авах;

7/зонхилон тохиолдох ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр боловсон хүчнийг мэргэжүүлэх, мэргэжлийг дэвшүүлэх арга хэмжээ авах;

8/зонхилон тохиолдох ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр анагаах ухаан, сувиллахуйн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийг хянан үзэж боловсронгуй болгох;

9/зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах талаар баримталж байгаа бодлого, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүн, хүн амын зан үйл, орчны өөрчлөлтийн байдалд хийх судалгааны ажлын төслийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх.

4.5.6. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/хүнсний найрлагыг бүрэн дүүрэн харуулах, хүн амд эрүүл сонголт хийх боломж олгох чиглэлээр хүнсний бүтээгдэхүүний шошгоны стандартыг "Хүнсний хууль эрх зүйн хорооны зөвлөмж", "Хүнсний бүтээгдэхүүний шошгоны Удирдамж Хууль"-ийн дагуу хянан шинэчилж мөрдүүлэх;

2/хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь давс, чихэр, тослогийн хэмжээг бууруулах чиглэлээр стандартыг хянаж шинэчлэн мөрдүүлэх замаар эрүүл зохистой хооллолтыг дэмжсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3/олон улсын болон үндэсний хоол тэжээлийн гарын авлагыг түгээх, эрүүл, зохистой хооллолтыг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүний шинэ

төрлийг үйлдвэрлэх, сурталчлах ажилд зах зээлийн урамшуулал үзүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

4/үр тариа, төмс, хүнсний ногоо болон хүнсний бусад бүтээгдэхүүнийг хадгалах технологийн горимыг чанд сахиулах, хүнсний бүтээгдэхүүнийг хорт хавдар үүсгэгч хор /афлатоксин/ ялгаруулдаг мөөгөнцрөөр бохирдохоос хамгаалах;

5/Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх.

4.5.7. Үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/давс, саахар, тослог багатай хүнсний бүтээгдэхүүн, жимс, ногооны хэрэглээг дэмжсэн импорт, экспортын бодлогын зохицуулалт хийж хэрэгжилтэд хяналт тавих

2/идэвхитэй хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөтөлбөрт дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамтран ажиллах;

3/хүн амын ахуйн хэрэглээний стандартад нийцсэн давсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авах.

4.5.8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/ажилтныг жилд 1-ээс доошгүй удаа нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч үр дүнг тооцож байх талаар ажил олгогч, ажилтны хүлээх үүрэг, хариуцлагын талаар хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжид тусгах;

2/ажлын байрны эрүүл ахуйн шаардлага, ажилтны аюул осолгүй, эрүүл орчинд ажиллах талаархи сургалт, сурталчилгааны ажлыг холбогдох байгууллага, иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах;

3/хөтөлбөрийн үйл ажиллагааг хүн амын хөгжлийн асуудлаархи үндэсний болон салбар хорооны үйл ажиллагаатай уялдуулах, жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах;

4/эмзэг бүлгийн хүн амын дунд ХБӨ-ий эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг мэргэжлийн байгууллагаатай хамтран хэрэгжүүлэх, хүн амын бүлгийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг татан оролцуулах.

4.5.9. Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/алхах, дугуйгаар явах болон бусад төрлийн хөдөлгөөн хийх боломжтой зам, талбайг нэмэгдүүлэх боломжийг судлан шийдвэрлэх;

2/шинээр барих барилга, орон сууц, зам талбайг төлөвлөхдөө алхах, дугуйгаар явах болон бусад төрлийн идэвхтэй хөдөлгөөн хийх боломжийг бүрдүүлэх.

4.5.10. Зам, тээвэр, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/нийтийн тээврийн үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, ач холбогдлыг нь сурталчлах;

2/хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн арга хэмжээ зохион байгуулах, боломж нөхцөл бүрдүүлэх.

4.5.11. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:

1/ээвсэгт хүчин, онцгой байдлын алба бусад цэргийн бие бүрэлдэхүүн болон цэргийн албан хаагчдын дунд ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйл /зохисгүй хооллолт, хөдөлгөөний хомсдол, архи, тамхи/-ээс сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэх.

4.5.12. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага:

1/ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч байх;

2/импортын хүнсний бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтыг олон улсын түвшинд хүргэж, хүнсний чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан нь бүрэн тогтоогдсон бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх;

3/хүний биед хортой, хорт хавдар үүсгэгч /канцероген/ бодис ялгаруулдаг үйл ажиллагааны онцлогтой болон цацраг идэвхит бодистой ажилладаг байгууллагын ажил, үйлдвэрлэлийн орчинд тавих хяналтыг тогтмолжуулах;

4/зонхилон тохиолдох ХБӨ-ий оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4.5.13. Стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага:

1/хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь давс, чихэр, тослогийн хэмжээг бууруулах чиглэлээр стандартыг шинэчлэн баталж мөрдүүлэх.

4.5.14. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга:

1/хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

2/хөтөлбөрт нийцүүлэн өөрийн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурлан ХБӨ-өөс сэргийлэх, хяналт тавих дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

3/эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлж ХБӨ-өөс сэргийлэх талаар байгууллага, хамт оны дотор хөдөлгөөн өрнүүлэх, дэмжлэг үзүүлэх, тэднийг сурталчлах, урамшуулах арга хэмжээ авах.

4/харьяа байгууллагын үйл ажиллагааг дүгнэхдээ ХБӨ-өөс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх талаар хийсэн ажлыг нэг үзүүлэлт болгон үнэлэх;

5/хавдар, чихрийн шижин өвчний үед үнэ төлбөргүй олгодог эмийн зардлын тооцоог нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагаар гаргуулан жил бүрийн төсөвтөө тусган санхүүжүүлэх, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

4.5.15. Хэвлэл мэдээллийн байгууллага:

1/эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлж эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх замаар ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, өвчтэй хүмүүс өөртөө хэрхэн хяналт тавих асуудлыг нийтлэл, нэвтрүүлгийн бодлогодоо тусган хэрэгжүүлэх;

2/зохистой, эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих, архи, тамхины хэрэглээг бууруулахад чиглэсэн энгийн, ойлгомжтой мэдээллийг олон нийтэд өгөх, энэ чиглэлээр бусад байгууллагад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.

4.5.16. Аж ахуйн нэгж, байгууллага:

1/ХБӨ-өөс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг тооцож жил бүрийн төсөвтөө тусган эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашгийг тооцож хэвших;

2/ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх талаар ажиллагсдын мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт явуулах, тэднийг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-2 удаа зохион байгуулалттайгаар хармуулж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/ажиллагсдад халуун хоолоор үйлчлэх, буцалсан, цэвэр ус уух боломж бүрдүүлэх, идэвхтэй хөдөлгөөн хийх, биеэ чийрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангаж архи, тамхигүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, энэ талаар амжилт олж байгаа нэгж, ажилтанг дэмжих, сурталчлах, тодорхой урамшуулал бий болгох;

4/үйлдвэрлэл, үйлчилгээнийхээ бодлогыг хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаанд нийцүүлэн ажиллах;

5/хүний биед хортой, хорт хавдар үүсгэгч /канцероген/ бодис агуулдаг үйл ажиллагааны онцлогтой ажил, үйлдвэрлэлийн орчинд тавих эрүүл ахуйн шаардлагыг чанд баримталж ажиллах;

6/цацраг идэвхит бодистой ажилладаг байгууллага орчны бохирдолтын түвшинд байнга хяналт тавьж ажиллагсдын хувийн болон хамт олны хамгаалалтын хэрэгслийг хэрэглэж хэвшүүлэх, хөдөлмөр хамгааллын бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4.5.17. Хүнсний үйлдвэр, зах, бүх төрлийн нийтийн хоолны газар:

1/ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйл болох мал, амьтны гаралтай өвх, тос, саахар болон давс, тамхи, согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, жимс, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр үйлчлүүлэгчдэд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах;

2/үйлчлүүлэгчдэд бүтээгдэхүүн болон түүний тэжээллэг чанарын талаархи мэдээллийг энгийн ойлгомжтой хэлбэрээр өгч эрүүл, тэжээллэг хүнс сонгох боломж бүрдүүлэх

4.5.18. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон бусад төрийн бус байгууллага:

1/хүнсний зүйлийн хэрэглээний талаар буруу мэдээлэл /чихэрлэг, давсалсан, нөөшилсөн, тослог ихтэй, хийжүүлсэн бүтээгдэхүүний хэрэглээг дэмжсэн/-д хяналт тавьж зохих мэдээлэл, эсрэг сурталчилгааг олон нийтэд хийж шаардлагатай арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран явуулж байх;

2/хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд оролцох.

4.5.19. Иргэд, олон нийтийн оролцоо:

1/эрүүл, зохистой хооллох, идэвхитэй хөдөлгөөн хийх, тамхи татахгүй байх, архи, согтууруулах ундааг зохистой хэрэглэх, архи, тамхинаас гарах талаар холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан удирдамж, гарын авлага, зөвлөмжийг мөрдөж, амьдрал ахуйдаа дадал хэвшил болгохын төлөө ажиллах, бусдад мэдээлэл өгөх чадварт суралцах;

2/биеийн жингээ зохистой хооллолт, идэвхитэй хөдөлгөөнөөр зохицуулах, цусны даралт, цусан дахь саахарын хэмжээгээ өөрөө хянах арга барилд суралцах, холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан мэдээлэл, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр зохиогдох арга хэмжээнд оролцох;

3/хүнсний зарим бүтээгдэхүүний талаар явуулж байгаа буруу мэдээлэл /чихэрлэг, давсалсан, нөөшилсэн, тослог ихтэй, хийжүүлсэн бүтээгдэхүүний хэрэглээг дэмжсэн/-ийн талаар холбогдох байгууллагад мэдэгдэх.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан бусад төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран улсын хэмжээнд, орон нутагт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Эх үүсвэр	Одосгийн түвшин 2005	Хүрэх үзүүлэлт	
				2009	2013
I. Аядагч эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэлт					
1	Хүн амын тамхины хэрэглээний түвшин (хувиар)	*	25.9	23.4	20.4
2	Согтууруулах ундаа хэрэглэдэг хүний эзлэх хувийн жин (сүүлийн нэг сард)	*	30.5	29.0	27.0
3	Давсны хэрэглээ (гр/өдөр)	*	10.1	9.6	9.1
4	Жимс хэрэглэж байгаа өдрийн тоо(долоо хоногт)	*	1.6	2.0	2.5
5	Хүнсний ногоог өдөрт 2-оос дээш нэгж хэрэглэж байгаа хүний тоо (хувиар)	*	44.4	49.4	55.0
6	Долоо хоногийн ихэнх өдөр, хоногт 30 минутаас доошгүй хугацаагаар дунд зэргийн болон нэмэлтээр тогтмол идэвхтэй хөдөлгөөн хийдэг хүний эзлэх хувийн жин	*	15.4	18.4	23.4
II. Хоёрдогч эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэлт					
7	Илүүдэл жинтэй хүний эзлэх хувийн жин (Биеийн жингийн индекс-БЖИ: 25 кг/м^2)	*	39.3	38.3	37.0
8	Цусны (артерийн) даралтын дундаж хэмжээ (мм/муб) а/ систол б/ диастол	*	а/128.5 б/79.4	а/128.0 б/78.9	а/127.5 б/78.4
9	Цусан дахь холестерин хэмжээ ихэссэн (>200 буюу 5.2 ммоль/л) тохиолдлын тархалтын түвшин (хувиар)	*	12.4	12.2	11.7
10	Цусан дахь глюкозын хэмжээ ихэссэн эрсдэлтэй (≥ 5.6 - $<6.1 \text{ ммоль/л}$) тохиолдлын тархалтын түвшин (хувиар)	*	10.2	10.0	9.8
III. Хавдрын эрт илрүүлэлтийн үзүүлэлт					
11	Умайн хүзүүний хорт хавдар нь оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь	Хавдар судлалын төвийн статистик 2004	33.1	34.0	35.0
12	Хөхний хорт хавдар нь оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь	-	29.1	30.0	31.0
IV. Нас баралтын үзүүлэлт					
13	Зүрхний шигдээсийн улмаас шалтгаалсан нас баралт (10 000 хүн амд)	Эрүүл мэндийн статистик үзүүлэлт 2004	2.7	3.5	3.0-3.4
14	Тархины цус харвалтаас шалтгаалсан нас баралт (10 000 хүн амд)	-	9.7	15.1	12.5-14.0
15	Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10 000 хүн амд)	-	12.1	11.8	11.5- 11.7

Тайлбар: (*) Үндэсний хэмжээнд хийгдсэн ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийн түвшин тогтоох суурь судалгаа. 2005 он

- Хүнсний ногооны нэг нэгж :
а/ нэг аяга түүхий ногоо
б/ хагас аяга чанасан ногоо

- Зүрхний шигдээсийн улмаас шалтгаалсан нас баралт жил тутам 0.3 пунктээр нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд хөтөлбөр хэргжүүлэн

нэмэгдэлтийн эрчмийг бууруулан 0.1 болгосноор 2009 онд нас баралт 3.5 болж нэмэгдэх боловч цаашдаа 0.3 пунктээр буурна гэж тооцоолов.

- Тархины цус харвалтаас шалтгаалсан нас баралт жил тутам 1.5 пунктээр нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд хөтөлбөр хэргжүүлэн нэмэгдэлтийн эрчмийг бууруулан 0.8 болгосноор 2009 онд нас баралт 15.1 болж нэмэгдэх боловч цаашдаа буурна гэж тооцоолов.

Засгийн газрын 2005 оны 246 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа	Үр дүн	Шалгуур үзүүлэлт
1	Зорилт 1. ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааг урьданд зохицуулах төгсгөртэй механизмгүй бүрдүүлэх талаар Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сүлжээ байгуулах	ЭМЯ	ХХААЯ, ҮХЯ, СЯ, БСШУЯ, ХЗДХЯ, БХБЯ, УМХГ	2006-2007	Салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалт сайжирна	Хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцсон төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн нэмэгдсэн хувь
2	Хөтөлбөрийн үйл ажиллагааг бусад хөтөлбөр, төсөл, арга хэмжээтэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх чиглэлээр уулзалт, ярилцлага зохион байгуулах	ЭМЯ	ХХААЯ, ҮХЯ, СЯ, ҮТЕГ, УТЕГ, БСШУЯ, ХЗДХЯ, БХБЯ, ЗТАЖЯ, ГХЯ, Олон улсын байгууллага (ЮНБ), ТББ	2006-2008	Хөтөлбөр, төслүүдийн хамтын ажиллагаа, харилцан уялдаа холбоо, үр ашг сайжирна	Уялдуулан хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны хувь
3	Аймаг, нийслэлд зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах салбар дундын ажлын бүлэг байгуулж ажиллуулах	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	ЭМЯ	2006-2007	Хөтөлбөрийн үйл ажиллагааны салбар дундын зохицуулалт сайжирна	Салбар дундын ажлын бүлэг байгуулсан шийдвэр
4	Зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах нэгдсэн үйл ажиллагааг арга зүйгээр хангаж ажиллах байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судлах	ЭМЯ	СЯ	2006-2007	ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагаа нэгдсэн арга зүйгээр явагдана	Зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах нэгдсэн үйл ажиллагааг арга зүйгээр хангаж ажиллах байгууллагын талаар гарсан шийдвэр
5	ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр амжилттай ажиллах үр дүнд хүрсэн хамт олныг нийгэд мэдээлэн сурталчлах, урамшуулах Талаар холбогдох яам, байгууллагатай хамтран ажиллах	ЭМЯ (ЭМХҮТ-Эрүүл мэндийн төвийн хөгжлийн үндэсний төв)	СЯ, НХХЯ, БСШУЯ, Олон нийтийн радио, телевиз (ОНРТ), Хэвлэл, мэдээллийн байгууллага	Жил бүр	Хамт олны оролцоо нэмэгдэнэ	Үр дүнд хүрч урамшуулагдсан хамт олны эзлэх хувь

	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо, Тайлан	Бэрхэм нотлоомд туушуулсан төлөвлөлт, үйл ажиллагаа явуулах боломжтой болно	2007-2013	БСШУЯ (ЭМШРИС)	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	Эрдэмт хүчин зүйлс (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	2006-2008	Эрдэмт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр эрх зүйн орчинг шийгшгэгдэнэ	Батлагдсан тогтоол шийдвэр, стандарт
13	Тамга, архим хэрэглээ, Гэдэргэрийн нийгэм эдийн засагт учруулах ороог үр дэвтгээр болон эвч үйлэрийн төрөлөлт, ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны эдийн засгийн болон эрүүл мэндийн үр дүн, үр ашгийн талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийгддэг эмэлжлэл үзүүлэх			ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	2006-2008	Эрдэмт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр эрх зүйн орчинг шийгшгэгдэнэ	Батлагдсан тогтоол шийдвэр, стандарт
14	Эрдэмт хүчин зүйлс (өөх тос, давс, саахар, архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хэмжээнийг бууруулах чиглэлээр одоо хэрэгжж байгаа эрх зүйн акт, стандартыг ханган боловсруулж болно)			ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	2006-2008	Эрдэмт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр эрх зүйн орчинг шийгшгэгдэнэ	Батлагдсан тогтоол шийдвэр, стандарт
15	Архи, тамхины онцгой албан тасгийн гэдэргэрийн хувьд эрүүл мэндийг дэмжих сан байгуулж хөгждэг эрүүл эвч үйл төлөвшилүүдэд "Эрүүл мэндийг дэмжих" орчин бүрдүүлэн ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны тогтвортой санхүүжилтийн механизмийг бий болгоход чиглэсэн арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх			ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	2005-2007	ХБӨ, Гэдэргэрийн эрхдэлт хүчин зүйлсийг бууруулах эрүүл мэндийг дэмжих ажлын ажиллагааны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр бий болго	Сан байгуулсан гэдэргэрийн хувьд эрүүл мэндийг дэмжих сангийн бүрдэлийн байрлал
16	Хөдөлгөөлт, хөдөлгөөн ба эрүүл мэндийн талаар дэлхий нийтээр баримтлах стратегийг хэрэгжүүлэх үндэсний удирдамж боловсруулж хэрэгжүүлэх			ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	2006-2007	Үндэсний онцролт тодорсон удирдамжтай болно	Батлагдсан удирдамжийг хэрэгжүүлсэн байгууллагын хувь
17	Хүн амд зохицсон хооллолт, идэвхитэй хөдөлгөөн болон архи, тамхиныг аж төрөх талаар мэдлэг, мэдлэг, дэдүн төлөвшилүүдэд чиглэсэн албан, албан бус болон эдийн засгийн хөтөлбөр, гарын авлага, аргатгал, зөвлөмж, МСС (мэдээлэл, сургалт, сурталчилгаа)-ны материалыг тэдний нас, хүйс, ажил мэргэжлийн онцролт тохируулан боловсруулах			ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	2006-2013	Албан, албан бус болон эдийн засгийн хөтөлбөр шийгшгэгдэнэ.	Батлагдсан сургалтын хөтөлбөр Хөгжсдөг гарын авлага, аргатгал, зөвлөмж, МСС-ны материалын тоо, чанар. Сургалтад хамрагдсан хүний тоо
18	Сургууль, аялал байранд эрүүл хоол, хүнсний зүйлсээр үйлдэх, хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх, "Эрүүл мэндийг дэмжих" орчин бүрдүүлэх талаар хамтарсан журам гаргаж мөрдүүлэх			НХХЯ, БСШУЯ	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, БТСУХ, ХСТ, ДТ, АУХ)	2006-2008	"Эрүүл мэндийг дэмжих" орчин бүрдүүлэх талаар хамтарсан журам, Хүн амын насны онцролт тохирсон хүнсний бүтээгдэхүүний стандарттай болно	Батлагдсан журам, удирдамж. Хэрэгжүүлсэн байгууллагын хувь
19	Эрүүл мэндийн хүнсний бүтээгдэхүүний үндэсний стандартыг ханган олон улсын жижигэр хүн амын насны онцролт тохирсон тослог, давс, саахрын хэмжээг бүтээгдэхүүний төрөл тус бүрээр шийгшсэн тогтоож мөрдүүлэх			ЭМЯ (НЭМХ, ХХААЯ, УХЯ, ТББ)	Зөрийн 2. Эрүүл амьдралын хэв маяг, эрүүл орчныг дэмжснээр ХБӨ-ий эрхдэлт хүчин зүйлсийн тувшрыг бууруулах талаар	ЭМЯ (НЭМХ, ХХААЯ, УХЯ, ТББ)	2006-2007	Хүн амын насны онцролт тохирсон хүнсний бүтээгдэхүүний стандарттай болно	Батлагдсан стандарт

20	Эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх чиглэлээр бодлого боловсруулагч, шийдвэр гаргалч нарт зориулсан ухуула, сурталчилгаа явуулах	ЗМЯ (ЭМХУТ, НЭМХ)	БСШУЯ (ЭМШУИС), ОНРТ, бусад хэвлэл, мэдээллийн байгууллага	2006-2008	Бодлого боловсруулагч, шийдвэр гаргалч нарын мэдлэг, хандлага дээшилэнэ	Ухуула, сурталчилгааны ажил, түүнд оролцогсдын тоо
21	"Эрүүл мэндийг дэмжих" сургууль, акцын байр, эмнэлэг шалгаруулах болзол, журмыг шинэчилж мөрдүүлэх	ЗМЯ (ЭМХУТ)	БСШУЯ,НХХЯ, аж ахуйн нэгж, байгууллага, ТББ	2006-2007	Шинэчлэгдэж батлагдсан болзол, журам	Болзол журмыг хэрэгжүүлсэн "Эрүүл мэндийг дэмжих" байгууллагын тоо, хувийн жин
22	Хүнсний бүтээгдэхүүний тэжээллэг чанарын хяналтыг сайжруулах талаар хүнс үйлдвэрлэгчид,импортолгочидтой хамтарсан уулзалт зөвлөлтөөнийг тогтмол хийх	ЗМЯ (НЭМХ)	ЗМЯ, УМХГ, ХХААЯ, УХЯ	2006-2012	Хамтын ажиллагаа сайжирна	Уулзалт, зөвлөлтөөнөөс гаргасан зөвлөмж, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн байдал
23	Хүнсний бүтээгдэхүүний химийн шинжилгээний үндэсний лавлагаа лаборатори байгуулах, чадавхийг дээшлүүлэх асуудлыг судлах	ЗМЯ (НЭМХ)	СЯ, УХЯ, ХХААЯ, УМХГ, ГХЯ	2006-2009	Хоол, хүнсний бүтээгдэхүүний тэжээллэг чанарын хяналтыг тогтвортой явуулах боломж бүрдэнэ	Үндэсний үйлдвэрлэл лаборатори байгуулсан тухай шийдвэр
24	Эрүүл хүнс үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүр шалгаруулах журам боловсруулж мөрдүүлэх	ЗМЯ (НЭМХ, ЭМХУТ, ДТ)	ХХААЯ, СЯ, УМХГ, УХЯ, ТББ	2006-2013	Эрүүл хоол, хүнсний үйлдвэрлэл нэмэгдэнэ	Эрүүл хоол, хүнс үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн хувь
25	Ажиллагсад, суралцагсад, үйлчлүүлэгчдийнхээ хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн талбай, ерөө гарган тохижуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулсан байгууллага, хамт олныг шалгаруулан үйл ажиллагааг нь сурталчлах	ЗМЯ (БТСУХ, ЭМХУТ)	НХХЯ,БСШУЯ, БХЯ, ОНРТ, бусад хэвлэл, мэдээллийн байгууллага	2006-2012	Нийтийн биеийн тамир идэвхтэй хөдөлгөөн хийхэд зориулсан талбай, ерөөтэй байгууллага, хамт олны тоо нэмэгдэнэ	Нийтийн биеийн тамир, идэвхитэй хөдөлгөөн хийхэд зориулсан талбай, ерөөтэй байгууллага, хамт олны тоо
26	ХБӨ-өөс сэргийлэх, хянах нэгдсэн үйл ажиллагааг төв, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг арга зүйгээр хангах үндэсний сургалч-багш болгох	ЗМЯ (НЭМХ, БТСУХ, ДТ)	БСШУЯ (ЭМШУИС)	2006-2007	Дасгалжуулагч, сургалч нар шинээр болон дагтан сургалтад хамрагдсан байна	Сургалтын тайлан, хамрагдсан хүний хувь
27	Хүн амын бие бялдрын чийрэгжилтийн байдлыг тодорхойлох шалгуурыг боловсронгуй болгон шинэчлэх	ЗМЯ (БТСУХ)	БСШУЯ СХЗТ	2006	Шалгуур боловсронгуй болно	Батлагдсан шалгуур

28	Чирэгжүүлэх, бөндөржүүлэх болон турсах төв, бүх төрлийн дасгал, хөдөлгөөнөөр сургалт явуулах байгууллага, төвийн үйл ажиллагаанд уналзах хийж тусгай зөвшөөрөл олгох асуудлыг судалж шийдэрлэх, стандарт, гарын авлага боловсруулж мөрдүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх	ЭМЯ (НЭМХ, БТСУХ, ЭМХУТ)	УМХГ, СХЗТ, аймаг, нийслэлийн Засаг дарга	2006-2007	Стандарттай болж төвүүдийн ажиллагсааны чанар дээшилнэ	Батлагдсан стандарт, гарын авлага, хэрэгжүүлсэн байгууллагын хувь
29	Шинээр барих болон засвар хийх барилга, орон сууцны хорооллыг оршин суугчид үйлчлүүлэгчдийн идэвхитэй хөдөлгөөнийг дэмжсэн зориулалтын эм, талбайтай байхээр төлөвлөлт-зэрэг төслийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ эвч	БХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг дарга, ЭМЯ (БТСУХ)	2006-2013	Оршин суугчид үйлчлүүлэгчдийн хөдөлгөөний идэвхи нэмэгдэнэ	Зориулалтын эм, талбайтай байхээр төлөвлөгдсөн барилга, орон сууцны хорооллын хувь
30	Оршин суугчдын идэвхитэй хөдөлгөөнийг дэмжсэн байр, талбай гэржэх, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ эвч хэрэгжүүлэх	БХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг дарга, Сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага	2006-2013	Оршин суугчид үйлчлүүлэгчид идэвхитэй хөдөлгөөн хийх боломжтой болно	Зориулалтын байр, талбай, шаардлагатай техник хэрэгсэл бүхий орон сууцны хорооллын хувь
31	Эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эрүүл аж төрөх талээр олон нийтийн зүгээс гарсан санхүүжилт, үйл ажиллагаа, жинжиг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	ЭМЯ (ЭМХУТ, НЭМХ, ХСТ, БТСУХ, ДТ)	БСШУЯ (ЭМШУИС), ТББ	2006-2013	Эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эрүүл аж төрөх талээр хэрэгжүүлэх арга хэмжээнд олон нийтийн оролцоо нэмэгдэнэ	Олон нийт, хамт олын зүгээс хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны хувь
32	Зарим аймаг, нийслэлийн дүүрэгт ХББ-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эрүүл мэндийг дэмжих талээр эгзвэр төсөл хэрэгжүүлж туршлагыг бусад аймаг, дүүрэгт сурталчлах, сургалт явуулах	Аймаг, нийслэлийн Засаг дарга	ЭМЯ (ЭМХУТ, НЭМХ, ХСТ, БТСУХ, ДТ)	2006-2013	Халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах талээр идэвхитэй ажилладаг аймаг, дүүргийн тоо нэмэгдэнэ	Аймаг, дүүргээс сургалтад хамрагдсан хүн, байгууллагын тоо
33	ХББ-ий эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны арга зүйн чиглэлээр ажиллах хүн хүчний гаднаад, дотоодод сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх	ЭМЯ	БСШУЯ (ЭМШУИС), ОУБ	2007-2013	ХББ-ий эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ажиллах хүний нөөцийн чадварыг дээшлэнэ	Гадаад дотоодод суралцсан хүний хувь



	Нийтийн биеийн тамир, спорт, чигэрлэлтийн арга хэмжээг хүн амын насны онцгой тохируулан зохион байгуулах, бүх насны хүн амыг хамруулах арга хэмжээг ахас	ЭМЯ (БТСУХ)	БСШУЯ, НХХЯ, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2006-2013	Биеийн тамир, чигэрлэлтийн болон хамарсан спортын арга хэмжээнд бүх насны хүн ам явд хамрагдсан байна	Зохсон байгуулсан арга хэмжээ, үрэгдэвч тэмцээний тоо, түүнд хамрагдсан хүний тоо, насны бүтэц
40	Нийтийн биеийн тамир, спорт, чигэрлэлтийн арга хэмжээг хүн амын насны онцгой тохируулан зохион байгуулах, бүх насны хүн амыг хамруулах арга хэмжээг ахас	ЭМЯ (БТСУХ)	БСШУЯ, НХХЯ, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2006-2013	Биеийн тамир, чигэрлэлтийн болон хамарсан спортын арга хэмжээнд бүх насны хүн ам явд хамрагдсан байна	Зохсон байгуулсан арга хэмжээ, үрэгдэвч тэмцээний тоо, түүнд хамрагдсан хүний тоо, насны бүтэц
41	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан "Идэвхитэй хөдөлгөөн" кампанийг олон зорхион байгуулах, хүүхдэд шинэ ашиг, үрэгдэвч тэмцээн зохион байгуулах	ЭМЯ (ЭМХУТ, БТСУХ)	БСШУЯ, ОНРТ	2007-2011	Сургууль, цэцэрлэгийн хүүхдэд зориулсан "Идэвхитэй хөдөлгөөн" кампанийг олон зорхион байгуулах	Кампанийг олон зорхион байгуулсан арга хэмжээ, үрэгдэвч тэмцээн, түүнд оролцогчдын хувь
42	Хүүхэд, залуучууд, нийт хүн амын дунд идэвхитэй болон явд хамарсан спортын болон цэнгээнт бүтээлийн сургалт явуулах арга хэмжээг гэрээжүүлэх	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	БСШУЯ, ЭМЯ (БТСУХ, ЭМХУТ)	2006-2012	Хүүхэд, залуучууд, нийт хүн амын дунд идэвхитэй болон явд хамарсан спортын болон цэнгээнт бүтээлийн сургалт явуулах арга хэмжээг гэрээжүүлэх	Олон нийтийн хөдөлгөөнийг идэвхитэй хөдөлгөөн хийж байгаа хувь
43	Зам, талбай, цэцэрлэгийн орны гэрээжүүлгийг сайжруулан тохируулах асуудлыг бодхыг ханган олон нийтийн идэвхитэй хөдөлгөөн хийж боломж, нөхцөлийг сайжруулах	Аймаг, нийслэлийн Засаг дарга	УМХГ, БУБЯ, СТАЖЯ, аж ахуйн нэгж, байгууллага	2006-2011	Зам, талбай, цэцэрлэгийн орны гэрээжүүлгийг сайжруулан тохируулах асуудлыг бодхыг ханган олон нийтийн идэвхитэй хөдөлгөөн хийж боломж, нөхцөлийг сайжруулах	Олон нийтийн хөдөлгөөнийг идэвхитэй хөдөлгөөн хийж байгаа хувь
44	Тамхигүй орчин бүрдүүлэх талаар, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд уралдаан зарлаж дарах, олон нийтэд сурталчлах	ЭМЯ (ЭМХУТ, СЭНТ)	БСШУЯ, НХХЯ, нийслэлийн Засаг дарга, мэдээллийн хэрэгсэл, ТББ	2006-2013	Тамхигүй орчин бүрдүүлэх арга зүйн гарын авлага, эхлэмж боловсруулж сургалт явуулах	Тамхигүй орчин бүрдүүлсэн байгууллагын хувь
45	Тамхигүй орчин бүрдүүлэх арга зүйн гарын авлага, эхлэмж боловсруулж сургалт явуулах	ЭМЯ (ЭМХУТ, СЭНТ)	Аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ	2006-2009	Тамхигүй орчин бүрдүүлэх арга зүйн гарын авлага, эхлэмж боловсруулж сургалт явуулах	Батлагдсан гарын авлага, сургалтад хамрагдсан хүний тоо өсөлт
46	Бүх шатны боловсролын байгууллагын албан хаагчид бус сургалтын агуулга, хөтөлбөрийг ханган тэмцээн хор хөнгөл, түүнээс сургалтын тэмцээнээс гаргах эрх зүйн ач холбогдолын талаар тусгах	БСШУЯ	ЭМЯ (ЭМХУТ, СЭНТ)	2007-2009	Бүх шатны сургалтын хөтөлбөр шинэчлэлтэд сургалтад нэвтрүүлсэн нөвтрүүлсэн суралцагчдын мэдлэг, хандлага	Батлагдсан шинэ хөтөлбөр, түүнийг сургалтад нэвтрүүлсэн боловсролын байгууллагын хувь

47	Тамхины хор хөнөөлийн талаар багш нарт зориулсан сургалт явуулах	БСШУЯ	ЭМЯ (СЭНТ, ЭМХУТ), ТББ	2006-2011	Тамхины хор хөнөөлийн талаар багш нарын мэдлэг, хандлага дээшилнэ	Сургалтад хамрагдсан нарын хувь	багш
48	Тамхинаас гаргах эмчилгээнд шаардлагатай эм хэрэгслийн хэрэгцээг тооцон хангамжийг сайжруулах чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан хамтарч ажиллах	ЭМЯ (СЭНТ)	Эм ханган нийлүүлэх байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага	2006-2013	Тамхинаас гаргах эмчилгээнд шаардлагатай эм хэрэгслийн хангамж нэмэгдэнэ	Тамхинаас эмчилгээнд шаардлагатай эм хэрэгслийн хангамжийн өсөлтийн хувь	гаргах
49	Тамхинаас гаргах эмчилгээ-сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх болон энэ талаар зөвлөгөө өгдөг утас ажиллуулах ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх	ЭМЯ (СЭНТ)	Эм ханган нийлүүлэх байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага	2006-2013	Тамхинаас гарахыг хуусан хүн зөвлөгөө авах эмчилгээ, хийлгэх боломжтой болно	Тамхинаас гаргах эмчилгээ-сургалтын хөтөлбөрт хамрагдсан хүний тоон өсөлт. Зөвлөгөө авсан хүний тоон өсөлт	гаргах
50	"Тамхигүй залуус", "Тамхигүй урлаг", "Тамхигүй спорт" зэрэг олон нийтэд зориулсан урлаг, соёлын арга хэмжээ, уралдаан тэмцээн, үйл явдал, арга хэмжээг "тамхигүй" зохион байгуулах талаар зөвлөмж гарган хэрэгжүүлэх	ЭМЯ (ЭМХУТ, НЭМХ, СЭНТ)	БСШУЯ, НХХЯ, ТББ, ОНРТ	2006-2012	Тамхигүй орчин, үйл явдал, арга хэмжээний нэмэгдэнэ	Тамхигүй орчин, үйл явдал, арга хэмжээний тоо	гаргах
51	Дэлхий нийтээр тамхи татахгүй өдөр /өдөр бүрийн 5 дугаар сарын 31/-ийг тэмдэглэн олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгаа (МСС) явуулах ажлыг аймаг, нийслэлийн хэмжээнд өргөжүүлэх	Аймаг, нийслэлийн Засаг дарга	ОНРТ, ЭМЯ (СЭНТ, ЭМХУТ)	2006-2013	Тамхины хор хөнөөл тамхинаас гаргах хэрэгцээг бууруулах, тамхигүй орчин бүрдүүлэхийн ач холбогдлын талаар олон нийтийн мэдлэг, хандлага дээшилнэ	Дэлхий нийтээр тамхи татахгүй өдрийг тэмдэглэдэг аймаг, дүүргийн хувь	нийтээр татахгүй өдрийг тэмдэглэдэг аймаг, дүүргийн хувь
52	Хөдөөгийн хүн ам, амьжиргааны түвшин доогуур болон орон гэргүй хүмүүст зориулсан тамхинаас гаргах сургалт, эмчилгээний стратеги боловсруулж хэрэгжүүлэх	ЭМЯ (СЭНТ, ЭМХУТ)	Аймаг, нийслэлийн Засаг дарга, НХХЯ	2006-2013	Хөдөөгийн хүн ам, амьжиргааны түвшин доогуур болон орон гэргүй хүмүүсийн мэдлэг, хандлага дээшилнэ	Батлагдсан сургалтын хөтөлбөр	Сургалтад хамрагдсан хүний тоо
53	Сар бүр архи хэрэглэдэггүй, худалдадаггүй өдөртэй болох, зөвлөмж гаргах, байгууллага, аж ахуйн нэгжийн дунд уралдаан зарлаж дүгнэх, олон нийтэд сурталчлах	Аймаг, нийслэлийн Засаг дарга	ЭМЯ, УМХТ, ТББ	2006-2013	Согтууруулах ундааны зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хэрэглээг бууруулах	Батлагдсан архи хэрэглэхгүй, худалдаагүй өдрийн тоо, архигүй орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	журим, архи хэрэглэхгүй, худалдаагүй өдрийн тоо, архигүй орчин бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийн тоо

54	Солгуурлах үндэсний хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөг зөвхөний хэрэглээний талар зөвлөгөө, зөвлөмж, МСС-ны материал боловсруулж олон нийтэд зориулсан сургалт, сурталчлалыг явуулах.	ЭМЯ (ЭМХУТ, СЭНТ)	БШУЯ (ЭМШУИС), ОНРТ, ТББ	2006-2013	Солгуурлах үндэсний хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөг зөвхөний хэрэглээний талар зөвлөгөө, зөвлөмж, МСС-ны материал боловсруулж олон нийтэд зориулсан сургалт, сурталчлалыг явуулах.	Гарсан зөвлөгөө зөвлөмж, МСС-ны материал болон мэдээлэл зөвч мэдээлэл болон хүний тоон өсөлт
55	Бүх шатны боловсролын байгууллын албан ёсоор болон бусад аргаар хөтөлбөрийг хангах үзэж солгуурлах үндэсний хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөг зөвхөний хэрэглээний талар зөвлөгөө, зөвлөмж, МСС-ны материал боловсруулж олон нийтэд зориулсан сургалт, сурталчлалыг явуулах.	БШУЯ (СЭНТ, ЭМХУТ)	ЭМЯ (СЭНТ, ЭМХУТ)	2007-2009	Бүх шатны үйлчилгээний хөтөлбөрийг хангах үзэж солгуурлах үндэсний хүний эрүүл мэндэд учруулах хор нөлөөг зөвхөний хэрэглээний талар зөвлөгөө, зөвлөмж, МСС-ны материал боловсруулж олон нийтэд зориулсан сургалт, сурталчлалыг явуулах.	Бэлтгэгдсэн хөтөлбөр, Сургалтад нэвтрүүлсэн байгууллагын хувь
56	Архичид болон тэдний гэр бүлийн хүмүүст туслах сайн дурын клуб амилуулах талар байгууллага, хамт олноос гарсан сонголтлод арга зүйн дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах.	ЭМЯ (ЭМХУТ, СЭНТ)	Аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ	2007-2013	Архичид болон тэдний гэр бүлийн хүмүүст туслах үйл ажиллагаа сайжирна.	Сайн дурын клубийн тоо зөвч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнд хамрагдсан хүний тоо
Зорилт 3. Сонхилон тохиолдох ХББ-ий хэлэлт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах талар						
57	Зонхилон тохиолдох ХББ-өөс сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо, эмчилгээний нэгдсэн удирдамж, стандартыг боловсруулж батлуулах.	ЭМЯ (ХСТ, ЭМХУТ, НЭМХ, ДТ)	БШУЯ (ЭМШУИС), Мэргэжлийн нийгэмлэг	2006-2012	Нэгдсэн удирдамж, стандартын дагуу тусламж, үйлчилгээ явуулах чандар нь дээшлэнэ.	Бэлтгэгдсэн удирдамж, стандарт
58	Зонхилон тохиолдох ХББ-өөс сэргийлэх, эрт илрүүлэх, оношилгоо эмчилгээний удирдамж, гарын авлага боловсруулах, эмч, эмнэлгийн амилтнуудад сургалт явуулах.	ЭМЯ (НЭМХ, ХСТ, ЭМХУТ, СЭНТ, ДТ)	БШУЯ (ЭМШУИС), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (БОУЭТ)	2006-2013	ХББ-ий менежмент сайжирна.	Бэлтгэгдсэн сургалтын хөтөлбөр, гарын авлага, Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний хувь
59	ХББ-ий оношилгоо, эмчилгээнд зориулагдсан орчин үеийн эм, бэлдмэлээс аюулгүй үнэйн боломжтой үр дүн сайтай эмийг зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад тусгах арга хэмжээ авах.	ЭМЯ (ХСТ)	БШУЯ (ЭМШУИС)	2006-2012	Эмчилгээнд орчин үеийн үр дүн сайтай эм, бэлдмэл нэвтрэнэ.	Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад шинээр тусгасан эм, бэлдмэл
60	ХББ-ий оношилгоо, эмчилгээнд шаардлагатай багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн хэрэгцээг тусламжийн шатлаар бүрээр гарган хангамжийг нэмэгдүүлэх асуудлыг гаднаад орлоодын хөрөнгө оруулагчид олон улсын байгууллага, хандивлагч орнуудад тавьж шийдвэрлүүлэх.	ЭМЯ	ГХЯ, СЯ, УХЯ, аж ахуйн нэгж, байгууллага	2006-2009	Техник хэрэгсэлийн хангамж сайжирна.	Техник хэрэгсэлээр хангамж эрүүл мэндийн байгууллагын хувь

68	Умийн хууруудыг хорт хавдрыг эрт илрүүлэхэд чиглэсэн 3 хувиан дууны хүрлийн арга. PAR нэвдсэн арга, хошийг хорт хавдрыг эрт илрүүлэхэд чиглэсэн хөх шинжээ болон зураг авах эзрэг бүсэд зонхилон тохиолдох ХЕӨ-ийг эрт илрүүлэхэд чиглэсэн өртөг зардал багатай, үр дүн сайтай арга-г нэвтрүүлэх.	ЭМЯ (ХСТ, ДТ)	Ажлагч Нийслэлийн Засаг дарга, БОЭТ, ЭМБ	2007-2013	Зонхилон тохиолдох ХЕӨ-ийг эрт илрүүлэх шинэ аргууд нэвтрэнэ	Батлагдсан шинэ арга, тэдгээрийг нэвтрүүлсэн ЭМБ-ын хувь. Илрүүлсэн тохиолдлын хувь
69	Зонхилон тохиолдох ХЕӨ-тэй хумуусийг бүртгэх, дуудах журам боловсруулж мөрдүүлэх.	ЭМЯ (ХСТ, ДТ, НЭМХ)		2006-2008	Бүртгэгдсэн өргөтгийг тоо нэмэгдэн хяналт сайжарна	Хяналтад авсан хуний нэмэгдсэн хувь
70	ХЕӨ-ий үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үргэлжлэсний чанарт хондрингийн хяналт хэмжэж журам боловсруулах	ЭМЯ (ЭМХУТ,ХСТ)	УМХГ	2006-2008	ХЕӨ-ий үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үргэлжлэсний чанар дээшилнэ	Батлагдсан тогтолцоо, журам, хондрингийн хяналт хийгдсэн эрүүл мэндийн байгууллагын хувь
71	Зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг таних, оноцоох, зөвлөгөө өгөх, сургалт явуулах, ханах теле-анагаахын тогтолцоог өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	ЭМЯ (ЭМХУТ, Анагаах ухааны хүрээлэн-АУХ, ХСТ)	СЯ, ГХЯ ОУБ	2007-2012	Зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг таних, оноцоох, зөвлөгөө өгөх, сургах, ханах үйл ажиллагаа	Теле-анагаахын тогтолцоонд хамрагдсан эрүүл мэндийн байгууллага, нэгжийн хувь
72	Архи, тамхиныг гаргах, илүүдэл жинг бууруулах, таргалалтын хэм шалтгааныг тодорхойлон эмчлэх эзрэг ХЕӨ-өөр өвчлэх эрдэл бүхий болон өвчтэй хүн амын дунд эрсдэлийн түвшинг бууруулах, хүндрэлээс сэргийлэхэд чиглэсэн удирдамж, хөтөлбөр, зөвлөмж боловсруулж, сургалт явуулах	ЭМЯ (НЭМХ, ЭМХУТ, ДТ, БТСУХ, СЭНТ)	БШУЯ (ЭМШУИС, ХХААЯ, МЭргэлтийн холбоо, клуб, ТББ	2006-2007	БШУЯ өвчлэх эрсдэл бүхий бүлгийн хүн амын дунд эрсдэлийн түвшин буурч эрүүл мэндийн байдал сайжарна	Батлагдсан хөтөлбөрүүд тэдгээрт хамрагдсан хуний хувь
73	ХЕӨ-ий эмчилгээнд нэн шаардлагатай эм, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг зохицуулах (үнэ, ханган нийлүүлэлт, өмчлөлийн өөрийн хяналт эзрэг) талаар журам гаргаж мөрдүүлэх	ЭМЯ	НХХЯ, СЯ Эм ханган нийлүүлэх байгууллагууд	2006-2009	ХЕӨ-ий эмчлэх, хүдрэлээс сэргийлэхэд нэн шаардлагатай эм, хэрэгслийн хангамж нэмэгдэнэ	Батлагдсан журам
74	ХЕӨ-ийг эвчлэн эрсдэлт хүчин зүйлс (цусны даралт ихсэлт, цусан даавь саажар ихсэлт, шээсэн дэх натрийн давс ихсэлт, илүүдэл жин эзрэг)-ийг өвчилсөн хүн өөрөө хэмжэж ханах, энэ ажиглалт гэр бүлийн гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн МСС-ны материал, аргачлалт гарган сургалт, сурталчилгаа явуулах	ЭМЯ (ДТ, НЭМХ, ЭМХУТ, БТСУХ)	БШУЯ (ЭМШУИС)	2006-2007	Өвчлэх эрсдэлтэй болон өвчтэй хүн амын өвчлөлийн ханах мэдлэг, дадал сайжарна	Өөртөө хяналт тавих мэдлэг, дадалтай хуний хувь

75	Цахирин шажантай хүний өвөрмөц хоол, хүнсний хангамжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	ХХААЯ	ЭМЯ (ДТ), ҮХЯ УМХ, мэдээллийн технологийн хэлтэс, аж ахуйн нэгж, байгууллага, ТББ	2006-2013	Цахирин шажантай хүний өвөрмөц хоол, хүнсний хангамж, нэмэгдсэн өргөний хэрэгслэл, сурвалж болгомог нэмэгдэнэ	Зорюулцалтын хоол, хүнсний зүйл хэрэглэдэг цахирин шажантай хүний тоон өсөлт
76	Хөнгөвчлөх эмчилгээний удирдамж боловсруулах, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтний модэлзийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	ЭМЯ (ХСТ)	БСШУЯ (ЭМШУИО), ТББ (Хөнгөвчлөх эмчилгээний сургалтын төв, ХЭСТ)	2006-2009	Хөнгөвчлөх эмчилгээний удирдамжтай болно. Нийт өрх, сумтай өвч нарын хөнгөвчлөх эмчилгээний талаархи мэдлэг, дэдлэг дээшлэнэ	Хөнгөвчлөх эмчилгээний удирдамж, Сургалтад хамрагдсан эмч, өргөний ачаа нарын хувь
77	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлдэг бэлтгэж аймаг, дүүрэгт байгуулж ажиллуулах	ЭМЯ (ХСТ)	Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, ТББ (ХЭСТ)	2006-2007	Аймаг, дүүрэг хөнгөвчлөх тусламж үйлчилгээний багтай болно	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний багтай аймаг, дүүргийн хувь, үйлдүүлсэн хүний хувь
78	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд шаардлагатай хянд уялтай, хурдан үйлчилгээтэй уулзаж хэрэглэдэг морфинь хангамжийг нэмэгдүүлэх, тасралтгүй хангахад чиглэсэн арга хэмжээ авах	ЭМЯ (ХСТ)	СЭ, ГХЯ, Мөнөөл Эм шилжсэн ханган нийлүүлэх байгууллагууд, ТББ (ХЭСТ)	2006-2009	Хянд уялтай, хурдан үйлчилгээтэй, уулж хэрэглэдэг морфинь хангамж сайжирна	Хэрэглэгчдийн хувь, тэдний хангамжийн байдал
79	Аймаг, дүүргийн хөдөө, дотор эмэгтэйтүүд, мэс заслын нарийн мэргэжлийн эмч нарт хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар суурь мэдлэг олгох сургалт явуулах	ЭМЯ (ХСТ)	Аймаг, нийслэлийн ЭМБ, ТББ (ХЭСТ)	2006-2009	Гэрээр үйлчилдэг бэлтгэвчлөх өгөх чадварыг нэмэгдэнэ	Сургалтад хамрагдсан мэргэжилтний хувь, эмч,
80	Хөнгөвчлөх эмчилгээнд шаардлагатай асаргаа, сувилгээний хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр тооцоо, судалгаа хийн эзэмшлэх, хандивлагч орнуудад санал тавьж хийдвэрлүүлэх	ЭМЯ (ХСТ)	СЭ, ГХЯ, Эм ханган нийлүүлэх байгууллага, ТББ (Монголын хөнгөвчлөх эмчилгээний нийгэмлэг)	2007-2009	Хөнгөвчлөх эмчилгээнд шаардлагатай асаргаа, сувилгээний хэрэгслийн хангамж, эрүүл мэндийн үйлдүүлэгчдийн хангамж сайжирна	Асаргаа, сувилгээний хэрэгслийн хангамж, нэмэгдсэн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын хувь
81	Хөнгөвчлөх эмчилгээний талаар гэр бүл, олон нийтийн мэдлэг, хандлага, дэдлэг дээшлүүлэх талаар гарын авлага, зөвлөмж гаргаж сургалт, сурталчилгаа явуулах	ЭМЯ (ХСТ, ЭМХУТ)	ТББ (ХЭСТ)	2006-2013	Хөнгөвчлөх талаар гэр бүл, олон нийтийн мэдлэг, хандлага, дэдлэг дээшлэнэ. Үйлдүүлэгчийн амьдралын чанар, хангамж дээшлэнэ	Гарын авлага, зөвлөмж, Сургалтад хамрагдсан гэр бүл, олон нийтийн хувь

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 248

Улаанбаатар хот

Үнэлгээ, хураамжийн хувь хэмжээ батлах тухай

Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ"-г 1 дүгээр, "Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай

2. Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Ховор амьтны жагсаалт"-ын "Нэг.Хөхтөн" гэсэн хэсэгт

"13.Хүрэн баавгай /Ursus arctos/ гэж, "Гурав.Загас" гэсэн хэсэгт "3.Тул /Hucho taimal/" гэж тус тус нэмсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай" Засгийн газрын 2001 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 264 дүгээр тогтоолын 2, 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2005 оны 248 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АН АМЬТНЫ ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

/мянган төгрөгөөр/

Ан амьтны нэр, хүйс, насны ялгаа	Экологи-эдийн засгийн үнэлгээ		
	эр	эм	төл
Нэг. Хөхтөн			
1 Тахь адуу	4000.0	5200.0	6800.0
2 Хулан адуу	2000.0	2600.0	3400.0
3 Хавтгай тэмээ	3700.0	4810.0	6290.0
4 Аргаль хонь	9000.0	11700.0	15300.0
5 Янгир ямаа	2000.0	2600.0	3400.0
6 Халиун буга	2500.0	3250.0	4250.0
7 Бараан хандгай	2800.0	3640.0	4760.0
8 Цаа буга /зэрлэг/	2000.0	2600.0	3400.0
9 Баданга хүдэр	2000.0	2600.0	3400.0
10 Бор гөрөөс	140.0	182.0	238.0
11 Зэрлэг гахай	200.0	260.0	340.0
12 Монгол бөхөн	2000.0	2600.0	3400.0
13 Хар сүүлтий	1500.0	1950.0	2550.0
14 Цагаан зээр	40.0	52.0	68.0
15 Цөөвөр чоно	1000.0	1300.0	1700.0
16 Саарал чоно	60.0	78.0	102.0
17 Шар үнэг	80.0	104.0	136.0
18 Хярс үнэг	40.0	52.0	68.0
19 Цроохор ирвэс	4000.0	5200.0	6800.0
20 Шилүүс мий	2000.0	2600.0	3400.0
21 Ойн булга	300.0	390.0	510.0
22 Суусар	300.0	390.0	510.0
23 Голын халиу	500.0	650.0	850.0
24 Голын минж	500.0	650.0	850.0
25 Заарт ондоотор	5.0	6.5	8.5
26 Нохой эзэх	15.0	19.5	25.5
27 Мануул	300.0	390.0	510.0
28 Халздай дорго	110.0	143.0	187.0
29 Хүрэн баавгай	2000.0	2600.0	3400.0
30 Мазаалай	5000.0	6500.0	8500.0
31 Алтайн Монгол тарвага	25	32.5	42.5
32 Бор туулай, чандага туулай	6.0	7.8	10.2
33 Нохой элбэнх	80.0	104.0	136.0
34 Өмхий хүрнэ	2.5	3.25	4.25

35	Эрээн хүрнэ	2.5	3.25	4.25
36	Солонго, ойн үен	5.0	6.5	8.5
37	Бусад зүйл үен	2.5	3.25	4.25
38	Бараан хэрэм	25.0	32.5	42.5
39	Цоохондой мий	500.0	650.0	850.0
40	Гозоорой зурам	5.0	6.5	8.5
41	Бусад зүйл зурам	1.5	1.95	2.55
42	Жирх	1.5	1.95	2.55
Хоёр, Шувуу				
1	Гангар хун	75.0	97.5	127.5
2	Гунгар, хуруут хун	60.0	78.0	102.0
3	Цагаан тогоруу	200.0	260.0	340.0
4	Хар, цэн тогоруу	75.0	97.5	127.5
5	Алаг тогоруу	37.5	48.75	63.75
6	Хонин, Жороо тоодог	75.0	97.5	127.5
7	Элээ	100.0	130.0	170.0
8	Борцгор хотон	500.0	650.0	850.0
9	Халбаган хошуут	9.0	11.7	15.3
10	Хар, дорнын өрөвтас	40.0	52.0	68.0
11	Махин галуу	40.0	52.0	68.0
12	Хээрийн галуу	40.0	52.0	68.0
13	Хошуу галуу	40.0	52.0	68.0
14	Одой галуу	40.0	52.0	68.0
15	Бусад зүйл галуу	10	13	17
16	Реликт цахлай	50.0	65.0	85.0
17	Гургуул	30.0	39.0	51.0
18	Алтайн хойлог	75.0	97.5	127.5
19	Байгалийн нугас	40.0	52.0	68.0
20	Бусад зүйл нугас болон ус намгийн шувуу	15.0	19.5	25.5
21	Ухаа шумбуур	10.0	13.0	17.0
22	Халзан ангир	10.0	13.0	17.0
23	Ямаан сүүлт	10.0	13.0	17.0
24	Усны бүх шувуу	10.0	13.0	17.0
25	Цасч дэглий	10.0	13.0	17.0
26	Азийн цууцал	10.0	13.0	17.0
27	Хилэн жигүүрт	10.0	13.0	17.0
28	Эгэл хүрэгэнэ	10.0	13.0	17.0
29	Бэгбаатар, ууль, шар шувуу	9.0	11.7	15.3
30	Идлэг шонхор	3000.0	3900.0	5100.0
31	Цагаан шонхор	1500.0	1950.0	2250.0
32	Амарын шонхор	500.0	650.0	850.0
33	Бусад зүйл шонхор	450.0	58.5	76.5
34	Хур, сойр	10.0	13.0	17.0
35	Хөтүү, ятуу, хахилаг, ногтруу	9.0	11.7	15.3
36	Тас, ел	100.0	130.0	170.0
37	Бүргэд, сар, харцага	100.0	130.0	170.0
Гурав, Загас				
1	Хилим, а/урт нь 1м-ээс дээш, б/урт нь 1 м хүртэл	200.0	260.0	340.0
2	Тул, а/урт нь 1м-ээс дээш	150.0	195	255
	б/урт нь 1 м хүртэл	100.0	130.0	170.0
3	Үхэрдэй	75.0	97.5	127.5
	40.0	52.0	68.0	
4	Цагаан амар	40.0	52.0	68.0
5	Давх	40.0	52.0	68.0
6	Занглаахай	40.0	52.0	68.0
7	Омоль, дархадын цагаан	4.5	5.85	7.65
8	Булуу цагаан	3.0	3.9	5.1
9	Хадран	2.0	2.6	3.4
10	Бусад зүйл загас	1.5	1.95	2.55

Засгийн газрын 2005 оны 248 дугаар
тогтоолын 2 дугаар хэвсрэлт

**АГНУУРЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, АН АМЬТАН АГНАХ,
БАРИХ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРААМЖИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ**

/мянган төгрөгөөр/

Ан амьтны нэр	Агнуурын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ		Ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ	
	Үйлдвэрлэлийн зориулалтаар агнах, барих	Соёл, шинжлэх ухааны зориулалтаар агнах, барих		
Нэг. Хөхтөн				
1	Тахь адуу		800.0	
2	Хулан адуу		400.0	
3	Хавтгай тэмээ		740.0	
4	Аргаль хонь		1800.0	
5	Янгир ямаа		400.0	
6	Халиун буга		500.0	
7	Бараан хандгай		560.0	
8	Цаа буга /зэрлэг/		400.0	
9	Баданга хүдэр		400.0	
10	Бор гөрөөс		28.0	28.0
11	Зэрлэг гахай		40.0	40.0
12	Монгол бөхөн		400.0	
13	Хар сүүлтэй		300.0	
14	Цагаан зээр	8.0	8.0	12.0
15	Цөөвөр чоно		200.0	
16	Саарал чоно*		18.0	
17	Шар үнэг		16.0	16.0
18	Хярс үнэг		8.0	8.0
19	Цоохор ирвэс		800.0	
20	Шилүүс мий		400.0	
21	Ойн булга		60.0	
22	Суусар		60.0	
23	Голын халиу		200.0	
24	Голын минж		100.0	
25	Заарт ондоотор	1.0	1.0	1.5
26	Нохой зээх		3.0	
27	Мануул		3.6	3.6
28	Халздай дорго		22.0	22.0
29	Хүрэн баавгай		400.0	
30	Мазаалай		1000.0	
31	Алтайн, Монгол тарвага	5.0	5.0	7.5
32	Бор туулай, чандага туулай		1.2	1.2
33	Нохой элбэнх		16.0	16.0
34	Эрээн хүрнэ		0.5	0.5

35	Өмхий хүрнэ		0.5	0.5
36	Солонго, ойн үен		1.0	1.0
37	Бусад зүйл үен		0.5	0.5
38	Барзан хэрэм	10.0	10.0	10.0
39	Цоохондой мий		100.0	
40	Гозоорой зурам	1.0	1.0	1.5
41	Бусад зүйл зурам	0.3	0.3	0.45
42	Жирх	0.3	0.3	0.45
Хоёр, Шувуу				
1	Гангар хун		15.0	
2	Гунгар, хуруут хун		12.0	
3	Цагаан тогоруу		40.0	
4	Хар, цагаан, цэн тогоруу		15.0	
5	Алаг тогоруу		7.5	
6	Хонин, Жороо тоодог		15.0	
7	Элээ**		20.0	30.0
8	Борцгор хотон		30.0	
9	Халбаган хошуут		1.8	
10	Хар, дорнын өрөвтас		4.0	
11	Махин галуу		8.0	
12	Хээрийн галуу		8.0	
13	Хошуу галуу		8.0	
14	Одой галуу		8.0	
15	Бусад төрлийн галуу**		2.0	
16	Реликт цахлай		10.0	
17	Гургуул		6.0	
18	Алтайн хойлог		15.0	
19	Байгалийн нугас		8.0	
20	Бусад зүйл нугас** болон ус, намгийн шувуу**		3.0	
21	Ухаа шумбуур		2.0	
22	Халзан ангир		2.0	
23	ямаан сүүлт		2.0	
24	Усны бух шувуу		2.0	
25	Цасч дэглий		2.0	
26	Азийн цууцал		2.0	
27	Хилэн жигүүрт		2.0	
28	Эгэл хүргэнэ		2.0	
29	Бэгбаатар, ууль, шар шувуу		1.8	
30	Идлэг шонхор		200.0	
31	Цагаан шонхор		100.0	
32	Амарын шонхор		100.0	
33	Бусад зүйл шонхор		90.0	
34	Хур**, сойр**		1.8	
35	Хөтүү**, ятуу**, хахилаг**, ногтруу**		1.8	
36	Тас, ёл		20.0	
37	Бүргэд**, сар, хэрцага		20.0	20.0 /зөвхөн бүргэд/

Тайлбар:

1. /*/ Чоныг ахуйн зориулалтаар төлбөр хураамжгүйгээр агнаж болно.

2. Энэ хэвсрэлтэд /**/ тэмдэг тавигдсан шувууг эрхийн бичиг буюу холбогдох зөвшөөрлийн дагуу ахуйн зориулалтаар агнаж, барьж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Хөтөлбөрийг үргэлжлүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөтөлбөрийг шинэчлэн батлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 219 дүгээр тогтоолоор баталсан "Бөөний худалдааны сүлжээ" шинэчилсэн хөтөлбөрт дараахь нэмэлт оруулсугай.

"21" 4 дүгээр үе шат 2005-2008 он

Энэ үе шатанд 1, 2, 3 дугаар үе шатанд хэрэгжүүлсэн арга хэмжээг үргэлжлүүлэн түүний үр дүнг дээшлүүлж, Баян-Өлгий, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган, Дундговь, Төв, Дархан-Уул аймгуудад "Бөөний худалдааны сүлжээ" байгуулж, түүхий эд бэлтгэлийг биржийн тогтолцоонд шилжүүлж, энэ ажилд бөөний худалдааны сүлжээнд ажиллаж байгаа аж ахуйн нэгжүүдийг оролцуулах арга хэмжээг хэрэгжүүлж дууссан байна."

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд С.Батболдод үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг 2008 он хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшилд олгосон зээлийн эргэн төлөлтийн хөрөнгөөс дахин эзэлдүүлэх замаар зохицуулахыг Сангийн сайд Н.Алтанхуягт зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД**
С.БАТБОЛД
САНГИЙН САЙД
Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

Жагсаалтад нэмэлт оруулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын иргэн У.Барсболд болон С.Гүрү Даваа Рэнбүчи нараас Монгол Улсын Засгийн газарт бэлэглэсэн эд хөрөнгийг зохих журмын дагуу төрийн өмчид бүртгэн авч Байгаль орчны яаманд хариуцуулсугай.

2. Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоолын хавсралтын "Нэг Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад байх объект" гэсэн

хэсэгт "8.Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн" гэж нэмсүгэй.

3. Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн арчилгаа, үйлчилгээг "Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэн" төрийн бус байгууллагад гэрээний үндсэн дээр хариуцуулж, холбогдох зардлыг Байгаль хамгаалах сангаас санхүүжүүлж байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
Ц.ЭЛБЭГДОРЖ
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД
У.БАРСБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Монгол

Улсын Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Засгийн газрын салбарын

тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн төрөл болон тэдгээрийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ын 36 дахь заалтын "Иргэний хамгаалалтын хүндэт тэмдэг-Батлан хамгаалахын сайд" гэснийг "Онцгой байдлын албаны тэргүүний ажилтан-Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд" гэж, 39 дэх заалтын "Хууль зүйн сайд"

гэснийг "Онцгой байдлын асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН
САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр**

Дугаар 260

**Улаанбаатар
хот**

**Эрүүл мэндийн даатгалын 2006 оны
шимтгэлийн хэмжээг тогтоох тухай**

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2006 онд аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн сар тутмын хэмжээг түүний

хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувь байхаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр**

Дугаар 264

**Улаанбаатар
хот**

**Тогтоолд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 1994 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 106 дугаар тогтоолын 1 дүгээр хэвсрэлтээр батлагдсан "Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм"-д дор дурдсан агуулгатай дараахь заалтуудыг нэмсүгэй:

"1. Цагдаагийн алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

2. Цагдаагийн алба хаагч эргүүл, харуулын үүрэг гүйцэтгэхэд Цагдаагийн байгууллагын тухай хууль болон энэ дүрэм, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно."

"13. Үнэт цаас, валют, алт эрдэнэсийг тээвэрлэлтийн үед хамгаалах үүрэгтэй харуулыг хамгаалан хүргэх харуул гэнэ."

"29. Нэмэгдлээр ажиллаж байгаа эргүүл, харуул нь нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын шуурхай албаны удирдлагын төвийн жижүүртэй байнгын холбоотой байж, нөхцөл байдлын талаар мэдээлнэ.

30. Эргүүл, харуул нь үүрэг гүйцэтгэсэн талаар ажлын тооцоо, тэмдэглэл хөтөлж, эргүүл, харуулд томилсон албан тушаалтанд танилцуулна.

31. Эргүүл, харуулд томилсон албан тушаалтан нь алба хаагчийн үүрэг гүйцэтгэж байгаа байдалд байнгын хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангана."

2. Цагдаагийн эргүүл, харуулын дүрмийн 4 дэх заалтын "... хооронд" гэсний дараа "явганаар болон ердийн хөсөг, тээврийн хэрэгсэлтэйгээр" гэж, 15 дахь заалтад "Нэгдсэн байршилтад түүнийг баталсан даргын шийдвэрээр нэмэлт тодотгол хийж болно" гэж тус тус нэмэх.

3. Дүрмийн 6 дугаар заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай.

"6. Цагдаагийн алба хаагч гудамж, талбай, үйлчилгээний газар, нийтийн тээврийн буудал зэрэг олон нийтийн газрын тодорхой хэсэгт хяналт тавих, онц чухал объектыг хамгаалах, шалган нэвтрүүлэх, гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх, үүрэг гүйцэтгэхийг цагдаагийн харуул гэнэ."

4. Дээр дурдсан нэмэлттэй холбогдуулан Цагдаагийн эрүүл, харуулын дүрмийн 1-ийг 3, 2-ыг 4, 3-ыг 5, 4-ийг 6, 5-ыг 7, 6-г 8, 7-г 9, 8-ыг 10, 9-ийг 11, 10-ыг 12, 11-ийг 14, 12-ыг 15, 13-ыг 16, 14-

ийг 17, 15-ыг 18, 16-г 19, 17-г 20, 18-ыг 21, 19-ийг 22, 20-ийг 23, 21-ийг 24, 22-ыг 25, 23-ыг 26, 24-ийг 27, 25-ыг 28, 26-г 32, 27-г 33, 28-ыг 34, 29-ийг 35, 30-ийг 36, 31-ийг 37, 32-ыг 38, 33-ыг 39, 34-ийг 40, 35-ыг 41 гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД

ХЭРГИЙН САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 265

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан

санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Н.Алтанхуягт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД

Н.АЛТАНХУЯГ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

П.ЦАГААН

Засгийн газрын 2005 оны 265 дугаар тогтоолын хавсралт

ХҮҮХДИЙН УРАН БҮТЭЭЛ ТУУРВИХАД ТӨРӨӨС САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мэргэжлийн урлагийн байгууллагууд, уран бүтээлчид хүүхдэд зориулсан уран бүтээл хийхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд энэ журмыг мөрдөнө.

1.2. Хүүхдэд зориулсан уран бүтээл хийх, уран сайхны кино бүтээх болон уран зохиол, танин мэдэхүйн ном хэвлэхэд санхүүгийн дэмжлэг авахаар ирүүлсэн төслийг хэлэлцэн шийдвэр гаргахад дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл (цаашид "мэргэжлийн зөвлөл" гэх) Соёл, урлагийн сангийн дэргэд ажиллана.

1.3. Мэргэжлийн зөвлөл нь тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын ажилтан, кино, драм, хөгжим, утга зохиол, ном хэвлэл, урлаг судлаачийн төлөөлөл бүхий 11 гишүүнтэй байна.

1.4. Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хоёр. Төслийн санхүүжилтийн зориулалт

2.1. Хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжих хөрөнгийг дор дурдсан төсөлд зарцуулна:

2.1.1. уран сайхны болон баримтат кино бүтээх;

2.1.2. сонгодог, үндэсний дуурь, бүжгийн жүжиг бүтээх;

2.1.3. өөрийн орны болон гадаадын зохиолчдын жүжгийг тавих;

2.1.4. хүүхэддэйн жүжиг, концертын хөтөлбөр бэлтгэх;

2.1.5. хүүхдийн сэдэвтэй дуу, найрал дуу, хөгжим болон концертын бүтээл туурвих;

2.1.6. циркийн хөтөлбөр хийх;

2.1.7. хүүхдийн уран зохиолын болон танин мэдэхүйн ном хэвлүүлэх;

2.1.8. симфони концерт хийх;

2.1.9. хүүхдийн урлагийн наадамд дэмжлэг үзүүлэх;

2.1.10. хүүхдийн сэдэвтэй зургийн үзэсгэлэн, уралдааныг дэмжих;

2.1.11. хүүхдийн дунд үндэсний уламжлалт урлалын уралдаан, үзэсгэлэнг зохион байгуулах.

Гурав. Төсөлд тавигдах шаардлага

3.1. Санхүүгийн дэмжлэг хүссэн төсөл нь дараахь шаардлагыг хангасан байна:

3.1.1. монголын үндэсний уламжлал, түүх, соёл, ёс заншлыг урлаг, уран сайхны өндөр түвшинд харуулсан;

3.1.2. хүүхдийн сонирхол, танин мэдэхүйн сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, технологийн ололтыг ойлгомжтой байдлаар харуулсан;

3.1.3. садар самуун, хүчирхийлэл болон мансууруулах бодис, алан хядлага зэрэг хуулиар хориглосон сөрөг үзэгдэл сурталчлаагүй байх.

Дөрөв. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

4.1. Мэргэжлийн зөвлөлийн хуралд ирүүлсэн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон зохиогчийн үнэлгээг үндэслэн уг төсөлд үзүүлэх хөрөнгийн хэмжээг тогтооно.

4.2. Хурлыг Мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

4.3. Мэргэжлийн зөвлөл нь ирүүлсэн төсөлд санхүүгийн дэмжлэг өгөх шаардлагыг хангаж байгаа эсэхэд тодорхой үндэслэл бүхий дүгнэлт гаргана.

4.4. Мэргэжлийн зөвлөлийн гаргасан дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай шийдвэр гаргана.

4.5. Мэргэжлийн зөвлөлийн гишүүний төсөл нь хурлын хэлэлцүүлэгт орж байгаа бол түүнийг хуралд оролцуулахгүй.

Тав. Төслийн шалгаруулалт ба санхүүжилт

5.1. Төслийн шалгаруулалтыг тухайн жилийн 1, 6 дугаар саруудад зохион байгуулна.

5.2. Төслийг Мэргэжлийн зөвлөл хэлэлцэхээс 1 сарын өмнө соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.3. Хүүхдийн уран бүтээлд зориулсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 4.5

☎ 329487

